



БОЛОВСРОЛ,
ШИНЭЖЛЭХ УХААНЫ ЯАМ



unicef
НҮБ-ын Хүүхдийн сан

ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Зохиогчид:

С.Энхтувшин

Доктор (PhD). Т.Цэндсүрэн

З.Болормаа

Г.Дуламжав

Хянан тунгаасан

Доктор (Sc), профессор С.Батхуяг

Улаанбаатар хот
2013

DDC
370.13
X-855

НҮБ-ын Хүүхдийн Сан 2013 он.
Монгол улсад хэвлэв.

Энэхүү гарын авлагыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачлагын хүрээнд хэрэгжиж буй “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ” төслийг хамтран хэрэгжүүлж байгаа цэцэрлэгүүдийн туршилт, судалгааны ажилд зориулан боловсруулсан бөгөөд гарын авлагын агуулга нь НҮБ-ын Хүүхдийн Сангийн байр суурийг шууд илэрхийлээгүй болно.

Нэгдсэн Үндэстний гудамж 12, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар, Монгол улс 210646
Утас: 976 (11) 312185
Факс: 976 (11) 327313
Цахим шуудан: Ulaanbaatar@unicef.org
Цахим хуудас: www.unicef.org/mongolia

ISBN 978-99962-56-88-2

АГУУЛГА

УДИРТГАЛ	5-14
Үндэслэл	5
Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн тухай ойлголт	6
Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний үзэл баримтлал, онолын үндэс	7
Гарын авлагын зориулалт ба ашиглах удирдамж	10
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн	
өөрийн үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд.....	15-32
1.1. Байгууллагын өөрийн үнэлгээний тухай ойлголт.....	15
1.2. Цэцэрлэгийн өөрийн үнэлгээний чиглэл ба агуулгын хүрээ	19
1.3. Үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд ба баримт цуглуулах арга, хэрэглүүр	19
ХОЁРДУГУУР БҮЛЭГ. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн	
өөрийн үнэлгээний хэрэгсэл	33-128
2.1. Эцэг эхээс авах үнэлгээний хуудас	33
2.2. Эцэг эхийн бүлэгтэй хийх ярилцлагын чиглэл	44
2.3. Эцэг эхтэй хийх ганцаарчилсан ярилцлагын асуулт	45
2.4. Багшаас авах үнэлгээний хуудас	46
2.5. Багш нарын бүлэгтэй хийх ярилцлагын чиглэл	60
2.6. Хичээлд ажиглалт хийх хуудас	62
2.7. Цэцэрлэгийн удирдлагаас (эрхлэгч, арга зүйч) авах үнэлгээний хуудас	66
2.8. Цэцэрлэгийн удирдлагатай хийх ярилцлагын асуулт	78
2.9. Баримт бичигт дүн шинжилгээ хийх хуудас	79
2.10. Цэцэрлэгийн орчинд ажиглалт хийх хуудас	80
2.11. Орон нутгийн удирдлагаас авах үнэлгээний хуудас	84
2.12. Орон нутгийн удирдлагатай хийх ярилцлагын асуулт	88
2.13. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд ба хэрэгслийн хамаарлын матриц	89
2.14. Үнэлгээний багийн ажлын хуудас	95
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Өөрийн үнэлгээнд тулгуурласан	
төлөвлөлт ба хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн хөгжил	130-137
3.1. Цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөө.....	130
3.2. Цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт, байгууллагын тасралтгүй хөгжил	136
Нэр томьёоны тайлбар	138
Ном зүй	140

ӨМНӨХ ҮГ

НҮБ-ын Хүүхдийн сан нь НҮБ-ын Хүн амын нутаг суурьшлын хөтөлбөр (НҮБ-ын ХАБИТАТ)- тэй хамтран 1996 онд Хүүхдэд ээлтэй хот санаачлагыг анх өхлүүлсэн нь хүүхдийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн цөмд авч үзэх олон талт хамтын ажиллагааны эхлэл болсон¹ билээ.

Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачлага нь Хүүхдэд ээлтэй дэлхий өртөнц тунхаглалын бүрэлдэхүүн хэсэг болохынхоо хувьд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх, хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд тавих, хүүхдийн эсэн мэнд амьдрах, өсч хөгжих, хамгаалулах, оролцох эрхийг хангах, хүүхдийн оролцоог хүндэтгэн дэмжих зэрэг зарчмуудыг үндэс болгодог.

Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачлагын үзэл санаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй, хөгжлийн орчин, өрх гэр бүлийн таатай орчин, хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, халамж, хамгааллын үйлчилгээ, хүүхдэд ээлтэй засаглал гэсэн дөрвөн үндсэн чиглэлийг хамарч байгаа болно.

Хүүхдэд ээлтэй байгууллага – цэцэрлэг нь хүүхдэд ээлтэй орон нутгийн салшгүй хэсэг мөн. Бага насын хүүхдийн амьдрах эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, хүүхэд бүрд эрүүл мэнд, боловсрол, халамж, хамгааллын чанартай үйлчилгээг тэгш хүртээмжктэй хүргэх боломжийг бүрдүүлэх зорилтыг орон нутагт хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх байгууллага нь хүүхдийн цэцэрлэг мөн.

Хэдийгээр хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үзэл санаа, санаачлагыг хот, хөдөөгийн олон цэцэрлэг дэмжиж, амжилттай хэрэгжиж эхэлж байгаа боловч түүний үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд, арга зүйг боловсруулах нь шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болоод байна. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний гарын авлагага”-ыг боловсруулан гаргаж байна. Гэхдээ энэхүү гарын авлага нь зайлшгүй дагаж мөрдөх хөдлөшгүй заавар, удирдамж биш гэдгийг онцлон тэмдэглээ. Гарын авлага нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн таван үндсэн чиглэл тус бүрийн хэрэгжилтийн явцыг үнэлэх шалгуур, үзүүлэлтүүд, үнэлгээний хэрэгсэл, ашиглах аргачлал болон үнэлгээнд тулгуурлан цэцэрлэгээ хөгжүүлэх төлөвлөгөөг хамтдаа боловсруулах алхмуудыг танилцуулах бөгөөд уншигч та эдгээрээс сонгон хэрэглэх боломжтой юм.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах нь ганцхан боловсролын салбарынхны үүрэг байсан мэт ойлголт өөрчлөгдөж, орон нутаг, олон нийтийн оролцоотойгоор шийдвэрлэх болсон нь Монголын нийгмийн сэтгэлгээнд гарч буй томоохон шинэчлэл, ахиц дэвшил юм.

Бидний хамтын ажиллагаанд тодорхой үр дүн гарна гэдэгт итгэлтэй байна.

У. Мандал

НҮБ-ын Хүүхдийн сангийн

Хүүхдэд ээлтэй орон нутаг багийн ахлагч

¹ Дэлхийн хүүхдийн байдал 2012

УДИРТГАЛ

Үндэслэл

Монгол улсын төр засгаас бага насны хүүхдийн хөгжил, боловсролын асуудалд ихээхэн анхаарал тавьж, хариуцлагатай ханддаг билээ. Өнөөдрийн хүүхэд бага насныхан ирээдүйн Монгол улсын хөгжлийн хөдөлгөгч хүч гэдгийг олон нийт хүлээн зөвшөөрдөг.

“Суралцах орчныг хүртээмжтэй, эрүүл байлгаж, тооноос илүү ЧАНАРЫГ эрхэмлэж, хүүхэд бүр өөртөө итгэх итгэлээ олж авсан, хөгжиж чадсандаа баяр бахархал дүүрэн байх хүүхдийн бүтээлч байдлыг дэмжсэн боловсролын үйл ажиллагааг амжилтанд хүргэхийн төлөө ажиллахыг”² боловсрол, шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн багаас уриалсан нь бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээний өнөөгийн чиг хандлагыг тодруулж байгаа юм.

Дэлхийн улс орнууд “Боловсролыг нэгдүгээрт” санаачлагад нэгдэж, хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмшүүлэхийг зорин ажиллаж байна. “Боловсролыг нэгдүгээрт тавьснаар, бид өлтгөлөн ядуурлыг багастаж, орхигдсон авьяас чадвар, нөөц боломжийг сэргээн, хөгжин цэцэглэсэн, сайн сайхан, хүчтэй нийгмийг бий болгох юм”³ гэж НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүүн уг санаачлагыг дэмжигчдэд хандаж хэлсэн байдаг.

Дэлхий дахинаа хүүхдийн эрхэд суурилсан боловсролын орчин, үйлчилгээг буй болгох, хөгжүүлэх замаар тэдний эрхийг хангах үзэл санааг дэмжин, бүх нийтийн боловсролын зорилтод тунхагласан “бага насны хүүхдэд зориулсан халамж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах” зорилтыг хэрэгжүүлэх олон шинэ санаачлага, бүтээлч ажлууд өрнөж байна.

Манай улс сургуулийн өмнөх боловсролын салбарт улсын нийт төсвийн 5,3%, боловсролын салбарын төсвийн 17,5%-ийг зарцуулж, хамран сургалтын цэвэр жин 2013 оны байдлаар 72,7%-д хүрч, засгийн газраас цэцэрлэгийн орчныг сайжруулах, сургуулийн өмнөх насны бүх хүүхдэд хүрч үйлчлэх, тэдний суралцах, хөгжих боломжийг жигд хангахад анхаарч байгаа зэрэг ололт амжилт байгаа хэдий ч орон нутаг, цэцэрлэгийн түвшинд шийдэл хүлээсэн асуудлууд оршсоор байна. Үүнд:

- Алслагдсан нутгийн малчдын хүүхдийн дийлэнх хэсэг⁴ нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа,
- Хүнам хэт төвлөрсөн хот суурин газрын цэцэрлэгийн ачаалал хэтэрснээс сургуулийн өмнөх насны хүүхдийн багагүй хувь нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа,
- Хүүхэд, ар гэрийн амьдралын нөхцөл байдал, боломж, хувийн онцлогийн ялгаатай байдал зэргээс шалтгаалан үе тэнгийн бусад хүүхдийн адил сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг адил тэгш, чанартай хүртэж чадахгүй байх,

2 Гантэмэр Л., Боловсрол, Шинжлэх ухааны сайд, “Боловсролын бодлогыг хүүхэд нэг бүрд”, “Эрдэм боловсролтой Монгол хүн” БШУС-ын Чанарын шинэчлэлийн хөтөлбөр, Уб., 2012

3 Бан Ги Мүүн, “Боловсролыг нэгдүгээрт” санаачлага, уулзалт., Нью-Йорк, 2012 оны 09-р сар.

4 2012-2013 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр, СӨБ-д хамрагдсан нийт хүүхдийн 30.561 буюу 16.9 хувь нь малчдын хүүхэд байна.

- Цэцэрлэгийн зарим багш, ажилтны харилцаа, хандлагын буруу үйлдлээс хүүхэд хохирох, эцэг эх мэдээлэл, эргэх холбоо авч чадахгүй байх, улмаар сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаанд оролцох идэвх сулрах, хайнга хандах,
- Цэцэрлэгийн орчны стандарт гэж байхгүйгээс шинээр баригдаж буй барилгууд нь орчин үеийн шаардлагад нийцэхгүй байх,
- Өнөөгийн цэцэрлэгийн орчин нөхцөл нь тэгш хамруулан сургах шаардлагыг хангаж чадахгүй,
- Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн цэцэрлэг, орон нутгийн төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааны тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, үйл ажиллагааны нэгдмэл сүлжээ буй болоогүй гэх зэрэг нь цэцэрлэгийн дэмжлэг туслалцаа авах, нэмэлт үйлчилгээний олон янзын арга хэлбэрийг ашиглах боломжийг хязгаарлаж байгаа,
- Орон нутгийн удирдлагын ойлголт, туршлага зэргээс шалтгаалан орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд бага насны хүүхдийн боловсролын асуудал тусгагдахгүй буюу хангалтгүй тусгагдах,
- Бага насны хүүхдийн боловсролын үйлчилгээн дэх талуудын оролцоо, ялангуяа нутгийн удирдлага, иргэдийн оролцоо хангалтгүй байсаар байна.

Иймд бага насны хүүхэд нэг бүр хаана амьдардаг, хэний хүүхэд болох, соёл, хөгжлийн ямар онцлог, ялгаатай, тухайн тойротг бүрд гэлтэй, бүрд гэлгүй эсэх зэргээс үл хамааран сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний үр шимиийг адил тэгш хүртэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Энэхүү бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн “Хүүхэд бүрд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэхэд баримтлах чиглэл⁵-ийг БШУЯ-аас боловсруулан гаргасан билээ. Хүүхэд бүрд ээлтэй цэцэрлэгийг хөгжүүлэх ажил нь цэцэрлэг бүр өөрийнхөө үйл ажиллагааны хүүхдэд ээлтэй байдлыг өөрөө судалж, үнэлэхээс эхэлнэ гэж үзэх энэхүү гарын авлагыг боловсруулан гаргаж байна. Уг гарын авлага нь цэцэрлэг орчин нөхцөл, үйл ажиллагааныхаа хүүхдэд ээлтэй байдлыг өөрөө үнэлэхэд ашиглах жишиг шалгуур, үзүүлэлтгүүд, үнэлгээнд оролцох субъект тус бүрд зориулсан хэрэгсэл, үнэлгээний үр дүнд тулгуурлан цэцэрлэгээ хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах аргачлал зэргийг агуулсан гурван бүлэг, 16 зүйлээс бүрдэнэ.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн тухай ойлголт

Монгол хэлний тайлбар тольд “ээлтэй” хэмээх үгийн үндсийг “юмны ач тус болох сайны хувь; хор хөнөөл үл болох”⁶ гэсэн утгатай гэж тайлжээ. Хүүхдэд ээлтэй байна гэдэг нь хүүхдийн өсөлт, хөгжилтэд саад, хор уршиг болохгүй байхыг хэлнэ. Цэцэрлэг хүүхдэд ээлтэй байхын утга учир нь тэндэх орчин, тэнд явагдаж буй бүхий л үйл ажиллагаа нь бага насны хүүхдийн эрүүл өсөн торниж, бие бялдар, оюун ухааны хувьд байгалийн зүй тогтол, өөрийн нөөц боломж, авьяасын дагуу хөгжин нийгэмших нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэж байхад оршино.

Бага насны хүүхдийн эрхийг хангах, сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээний үр шимиийг хүртэх боломжийг хүүхэд бүрд олгож, хүүхэд бүрийн оролцоог дээдэлж ажилладаг цэцэрлэгийг хүүхдэд ээлтэй цэцэрлэг гэнэ.

5 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 04-р сарын 10-ны өдрийн А/110 тушаал

6 Цэвэл Я., “Монгол хэлний төвч тайлбар толь”, Уб., 1966, 894 дэх тал.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь хүүхэд бүхэнд нээлттэй, тэднийг урин дууддаг цэцэрлэг юм. Эл мөн чанар нь цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд хүрч үйлчилж байгаа, харьяа орон нутгийнхаа бага насны хүүхдийн сайн сайхан байдал, тэдний эрхийг хамгаалахад хяналт тавьж, тусалж чадаж буй шинжээр илэрнэ. Өөрөөр хэлбэл, бүх хүүхдийг (эрэгтэй, эмэгтэй, хэл, соёлын ялгаатай, тусгай хэрэгцээтэй, алслагдсан орон нутгийн, нийгмийн эмзэг бүлгийн гэх мэт) боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах бодлого баримталж ажиллана гэсэн үг.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь хүүхэд төвтэй бодлого, үйл ажиллагаа явуулдаг байгууллага мөн. Энэ чанарыг хүүхдийн эрх ашиг, сонирхлыг дээдлэн, хүүхэд бүрийн онцлог ялгааг харгалзаж, хүүхдийг бүхий л талаас нь (эрүүл мэнд, хоол тэжээл, оршин байхуй г.м) анхаарч ажиллаж буй байдлаас харж болно.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь хүүхэд хувь хүнийхээ хувьд төдийгүй нийгмийн бяцхан гишүүний хувьд өсч хөгжих, амьдрах орчин мөн. Уг орчны ая тухтай байдлыг хүүхэд бүрийн бие махбод, сэтгэлзүйн аюулгүй, хамгаалагдсан байдлаар таньж болно.

Хүүхэд бол жам ёсны суралцагч, бас суралцах чадавхитай нэгэн. Гэвч энэ нь зарим талаар хязгаарлагдах нь буй. Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь тэдгээр саад бэрхшээлийг таньж илрүүлэн, тохиромжтой орчныг бүрдүүлэх замаар суралцах, хөгжих боломжийг нэмэгдүүлж, дэмжлэг үзүүлдэг, бас тэдний онцлог, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь үйл ажиллагаандаа хүүхэд бүрийн хувийн онцлог, хэрэгцээ сонирхолд хүндэтгэлтэй хандах, тэдгээр нийцсэн арга барилаар ажиллах, хүүхэд бүрд өөрийгөө илэрхийлэх, үйл ажиллагаанд оролцох боломж олгох, гэр бүл, олон нийтийн оролцоонд тулгуурлах зарчмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа эрхэмлэдэг.

Цэцэрлэг ийнхүү хүүхэд бүрд ээлтэй байхын тулд гэр бүл, олон нийт, орон нутгийн дэмжлэг, оролцоог хүлээн авч, хамтран ажиллах хэрэгтэй. Үүнд цэцэрлэгийн хамт олны хариуцлагатай тайлагнал, манлайлал чухал үүрэгтэй. Үндэслэл, нотолгоотой, хариуцлагатай тайлан нь үйл ажиллагаандаа хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээнд тулгуурладаг. Баримт нотолгоонд тулгуурласан үнэлгээ нь дараагийн шатны үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөх боломжийг цэцэрлэгт олгоно. Нөгөө талаар, орон нутгийн болон цэцэрлэгийн удирдлага үнэлгээгээр илэрсэн дутагдалд анхаарлаа хандуулж, зохицуулалт нэн шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, санхүүжилтийг оновчтой шийдвэрлэх боломж бүрдэнэ.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үнэлгээний үзэл баримтлал, онолын үндэс

Хүүхдийн хүмүүншин төлөвших хамгийн чухал суурь нас бол 0-5 нас байдаг. Хүүхэд хэлд орж, бусадтай харилцаж сурх үеэс эхлэн үндсэндээ таван нас хүрэхэд ирээдүйд ямар хувь хүн болох суурь нь тавигддаг. Энэ нь сургуулийн өмнөх нас хүний төлөвшлийн чухал үе болохыг илтгэнэ.


Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаанд бага насны хүүхдийн бие бялдар, эрхтэн махбод, сэтгэл санааны байдлыг нас бага, цус шингэн, яс нимгэн, ёс цөөхөн, судал тамир хөнгөн гэх зэргээр тодорхойлж, хан хөвгүүн мэт асарч хүмүүжүүлэхийг сургамжилсан буй. Ишдан занваанжил “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал”-даа асралыг мэдрүүлэх тухай айлдсан нь учиртай. Хүүхдийг нялх балчир насанд нь өсгөж бойжуулахад эцэг эхийн хайр асрал үнэхээр чухал. Манай уламжлалт сурган

хүмүүжүүлэх ухаанд тав хүртэлх насыг хүүхэд аав, ээж, асран хамгаалагч, насанд хүрэгчдээс энхрий хайр, асран сувилсан ачлал, зөвлөн эвлэг харилцааг хүлээж байдаг үе⁷ гэж үздэг. Иймээс энэ насны хүүхдүүдэд үйлчилж буй хүмүүс хүүхэд бүрд эй асрахуй, нигүүлсэхүйн сэтгэлээр хандаж, харилцах нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн нэгэн шаардлага байх учиртай.



Юри
Брофенбреннер
(1917-2005)

Хүүхдийн хөгжлийн тухай биологийн, зан үйлийн/бихевиор ба нийгмийн суралцахуйн, психодинамик, танин мэдэхүйн хөгжлийн, нийгэм-соёлын, хөгжлийн тогтолцооны гэх зэрэг олон онол бий. Тэдгээрийн нэг нь хүүхдийн хөгжилд олон хүчин зүйл харилцан нэлөөлж байдаг тухай тогтолцооны онол юм. АНУ-ын судлаач Юри Брофенбреннерийн хүний хөгжлийн тухай био-экологийн үзэл баримтлалд үндэслэн хөгжсэн эл онолыг экологи тогтолцооны онол хэмээн нэрлэх нь ч буй. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийг хүүхдэд ээлтэй орон нутгийн нэгэн хэсэг, нэг институци гэж үзвэл тэнд өсч торниж буй хүүхдийн хөгжил, түүнд нэлөөлж буй үйлчилгээ, тэдгээрийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулахдаа бид экологи тогтолцооны онолд тулгуурлах нь зүйтэй гэж үзсэн юм.



Зураг 1. Хүүхдийн хөгжлийн экологи тогтолцооны загвар

7 Баттогтох Д., "Үр хөвгүүнийг сургах ёсон", Уб., 2009, х. 43-46.

Тэрээр уг онолоороо хүүхдийн хөгжилд хүрээлэн буй орчин чухал үүрэгтэйг тодорхойлоод, уг орчны “давхаргууд”-ын харилцан үйлчлэлийг илрүүлсэн билээ. Брофенбреннер хүүхдийн өөрийнх нь биологи үндэс нь түүний хөгжлийг өдөөх анхдагч орчин гэж үзжээ. Хүүхдийн биологи тогтолцоо (танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн тогтолцоо болон бие эрхтний систем) нь гэр бүл, хамт олон, олон нийт, нийгмийн институттэй харилцан үйлчилж, түүний хөгжлийг жолооддог. Аль нэг давхаргад гарсан өөрчлөлт өсвэл зөрчил нь бусад давхаргадаа нөлөөлдөг ажээ. Эл нөлөөллийг Брофенбреннер “долгио тархаж байгаа” мэт⁸ гэж зүйрлэжээ. Иймд хүүхдийн хөгжлийг судлах, тэдэнд туслахыг хүссэн хэн бүхэнд зөвхөн хүүхдийг өөрийг нь, өсвэл түүний ойрын орчныг (жишээ нь, гэр бүл, цэцэрлэг, сургууль г.м) авч үзэх нь хангалтгүй бөгөөд харилцан үйлчлэлийг өргөн хүрээнд харахыг санал болгосон аж. Тэрхүү харилцан үйлчлэл нь дөрвөн гол давхаргад явагдах бөгөөд давхарга бүр тодорхой дүрэм журам, хэм хэмжээ, үүрэгтэй төдийгүй тэдгээр нь хүүхдийг хөгжин, төлөвшихөд чухал нөлөө үзүүлдэг гэжээ.

Микро давхарга нь хүүхэдтэй хамгийн ойр байгаа, түүнтэй шууд холбогдож харилцаж байгаа хүмүүс, нэгжээс бүрдэнэ. Энэ давхарга нь хүүхэд, түүнийг хүрээлж буй ойрын орчинтойгоо тогтоосон харилцаа, харилцан үйлчлэлийг агуулж байдаг. Энэхүү микро давхаргын бүтцэд гэр бүл, цэцэрлэг, сургууль, хөршүүд, хүүхдийн хөгжлийн төв, клуб орж болно. Энэ түвшинд харилцаа, түүний нөлөөлөл нь хоёр чиглэлтэй байна. Нэг талаас, хүүхэд рүү чиглэсэн, нөгөө талаас хүүхдээс түүнийг хүрээлж буй орчин руу чиглэсэн харилцаа байна. Жишээ нь, аав ээж нь хүүхдийнхээ итгэл үнэмшил, дадал зуршил (бусдыг хүндэтгэх, хоол идэхийн өмнө гарaa угаах г.м)-д нөлөөлөх бол, нөгөө талаас хүүхдийн хөгжил, төлөвшилд гарч буй ахиц өөрчлөлт аав ээжийн хандлага, үзэл бодол(цэцэрлэгийн үйл ажиллагагааг дэмжих, оролцох)-д нөлөөлж болно. Брофенбреннер үүнийг харилцан нөлөөлөл гэж нэрлээд, тэдгээр нь хүрээлэн буй орчны бүхий л түвшинд хэрхэн тохиолдож болохыг авч үзсэн байдал. Нэг давхаргын бүтцийн элементүүдийн харилцан үйлчлэл, давхаргууд хоорондын харилцан үйлчлэл нь энэхүү онолын гол санаа мөн. Ялангуяа, микро давхаргад хоёр талын харилцан нөлөөлөл маш хүчтэй байх тул хүүхдэд тэр хэмжээгээр нөлөөлдөг. Гадна давхаргуудын харилцан үйлчлэл нь ч дотоод бүтцэд нөлөөлөх аж.

Харин мезо давхарга нь хүүхэдтэй шууд харилцаж буй орчин хоорондын (хоёр ба хэд хэдэн орчин) харилцан үйлчлэлийг агуулна. Жишээ нь, багш, ажилтны харилцааны доголдлоос үүдэлтэй хүүхдийн сэтгэл санааны таагүй байдал нь эцэг эхийн дургүйцлийг хүргэж, улмаар гэр бүл, цэцэрлэгийн хоорондын харилцаанд таагүй уур амьсгал үүсэх, энэ нь хүүхдийн суралцах, хөгжих үйл явцад урвуу нөлөөлж болох юм.

Экзо давхарга нь хүүхэдтэй шууд харилцахгүй, нийгмийн томоохон давхарга юм. Уг давхаргын элементүүд нь микро давхаргын зарим элементтэй харилцан үйлчлэх замаар хүүхдийн хөгжил төлөвшилд нөлөөлдөг. Жишээ нь, эцэг эхийн ажил эрхлэлт, хүүхэддээ зориулах цаг зав, тухайн орон нутгийн гэр бүлийг дэмжих нөөц зэрэг нь хүүхдийн хөгжил, төлөвшилд нөлөөлнө. Хүүхэд хэдийгээр уг давхаргад шууд хамаарахгүй ч түүний эерэг, сөрөг нөлөөллийг мэдэрнэ. Иймд экзо давхаргын хүчин зүйлсийг тооцсон бодлого, төлөвлөлт зайлшгүй хэрэгтэй. Үүний тулд тухайн орон

⁸ Addison, J.T. (1992). *Urie Brofenbrenner. Human Ecology*, 20 (2), p. 16-20.

нутаг хүүхэд, гэр бүлийг дэмжсэн бодлого баримталж, хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олны тоо нэмэгдсэнээр илүү олон хүүхэд үр шимиийг нь хүртэх учиртай.

Тулгуур зарчмуудаар дамжуулан бусад давхаргын харилцан үйлчлэлд, улмаар хүүхдийн хөгжил, төлөвшилд нөлөөлөх макро давхарга нь тухайн нийгмийн соёлын нийтлэг үнэт зүйлс, ёс заншил, хууль дүрэм зэргийг агуулдаг. Жишээ нь, тухайн нийгэмд бага насны хүүхдийн хөгжлийг эцэг, эхээс илүүтэй цэцэрлэг, багш нар л хариуццах ёстой гэсэн итгэл үнэмшил зонхиilk байгаа бол нийгмээс эцэг эх, гэр бүлд үзүүлэх дэмжлэг сул байх болно. Энэ нь эргээд эцэг эхийн хандлага, үйл ажиллагаанд нөлөөлнө. Улмаар эцэг эхийн мэдээлэл, мэдлэггүй, хариуцлагагүй байдал нь хүүхдийн хөгжил төлөвшилд сөргөөр нөлөөлөх уршигтай.

Дээрх онолын гол санаа нь бага насны хүүхдэд үйлчилж буй байгууллага төдийгүй тэдний гэр бүл, амьдарч буй орон нутаг бүхэлдээ хүүхдийн сайн сайхны төлөө бодлого, үйл ажиллагаа явуулахад чиглэж байгаа тул хүүхдэд ээлтэй орон нутгийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг болох цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх арга зүй, хэрэгслийг боловсруулах тулгуур үндэс болгон авсан юм.

Хүүхдийн хөгжил төлөвшилд хандах биогенетик, социогенетик, психогенетик, холистик гэх зэрэг олон хандлага байдаг. Бидний тулгуурлаж буй экологи тогтолцооны онолын үүднээс харвал, хүүхдийн хөгжил төлөвшилд олон хүчин зүйл харилцан нөлөөлөх бөгөөд хөгжилд зонхилох нөлөө үзүүлэх нэг хүчин зүйл байх боломжгүй юм. Энэ үзэл санаа нь хүүхдийн хөгжил төлөвшлийн асуудалд цогц хандахад хүргэж байна. Нөгөө талаар хүүхдийн хөгжил, хөгжих буй орчин нөхцлийн динамик харилцааны тухай үзэл санаа нь хүүхэдтэй ойр дотно ажилладаг багш, цэцэрлэгийн ажилтны үзүүлж буй үйлчилгээ нь ч тэдний амьдарч буй орчин, гэр бүл рүү нь цогц хандахыг шаарддаг. Иймд хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь хүүхдийн хөгжил, төлөвшлийн аливаа асуудалд холистик буюу цогц хандах бөгөөд цэцэрлэгийн өөрийн үнэлгээнд ч энэ асуудал хамаарна. Ийм ч учраас хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжил өөр хоорондоо нягт уялдаа холбоотой явагдаж, харилцан нөлөөлөхийн зэрэгцээ тэдгээр нь хэвийн явагдах үндсэн нөхцлийн нэг нь хүүхдийн хоол тэжээл, эрүүл, аюулгүй орчин гэж үзэн, асуудалд цогц хандахыг хичээж байгаа болно.

Монголчууд хэдийгээр “арван хуруу тэгш хүн байдагтүй” гэж хэлэлцдэг боловч хүнийг үзэх үзлийн дээд баримтлал нь өв тэгш хөгжлийн тухай ойлголт буюу “үлэмжийн чанар төгөлдөр” хүмүүний тухай сургаал билээ. Энэ нь угтаа хүний, тэр дундаа хүүхдийн хөгжил, төлөвшилд цогц хандахыг сургамжилж буй хэрэг юм.

Гарын авлагын зориулалт ба ашиглах удирдамж

Гарын авлагыг хэн, юунд хэрэглэж болох вэ?

Энэхүү гарын авлагыг бага насны хүүхэдтэй ажилладаг, тэдний төлөө санаа тавьдаг хүмүүст, тэр дундаа ТАНД зориулсан. Хэрэв та цэцэрлэгийн багш, туслах багш, ажилтан (эмч, тогооч, жижүүр г.м), арга зүйч, эрхлэгч бол та энэхүү гарын авлагын хэрэглэгч мөн.

Таны хүүхэд цэцэрлэгт явдаг, эсвэл харьяа орон нутгийнхаа цэцэрлэгээс үйлчилгээ авдаг (авахыг хүсдэг) бол та энэхүү гарын авлагын бас нэгэн ХЭРЭГЛЭГЧ мөн.

Та орон нутгийнхаа засаг захиргаа, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагад ажилладаг бол, бага насны хүүхдийн хөгжилд санаа тавьдаг, цэцэрлэгийн үйлчилгээг

үнэлэхэд оролцож, дэмждэг нэгэн бол ТА энэ гарын авлагыг анхааралтай судалж, ашиглаарай.

Хэрэв та сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх ажилд оролцдог бол та “Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ” гарын авлагыг уншиж сонирхох хүмүүсийн нэг мөн.

Уг гарын авлага нь цэцэрлэг бодлого, төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт, үйл ажиллагааныхаа хүүхдэд ээлтэй байдлыг үйлчлүүлэгчдийн оролцоотойгоор өөрийн үнэлгээ хийх, уг үнэлгээний үр дүнд тулгуурлан цэцэрлэгээ хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад зориулагдсан тул хүүхдийн төлөө ажиллаж буй БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОН та бүхэн уншигч, хэрэглэгч нь мөн.

Гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?

“Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ” гарын авлагыг цэцэрлэг хүүхдэд ээлтэй, чанартай үйлчилгээ үзүүлж буй эсэхээ үйлчлүүлэгчид, орон нутгийн удирдлага, олон нийтийн төлөөллийн оролцоотойгоор үнэлэх, үнэлгээний үр дүн, баримт нотолгоонд тулгуурласан төлөвлөлт хийх, үйл ажиллагаагаа сайжруулахад ашиглах юм.

Уг гарын авлага нь “хүүхэд бүр онцлог ялгаатай”, тэд бүгд боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш эрхтэйг хөхүүлэн дэмжсэн, бага настын хүүхэд бүрийг тэгш хамран сургах үзэл санаанд тулгуурласан болно.

Гарын авлага гурван бүлгээс бүрдэх бөгөөд бүлэг бүрийг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна уу.

Нэгдүгээр бүлэгт үнэлгээний үндсэн чиглэл, чиглэл тус бүрийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг буюу үнэлэх зүйл, ашиглах шалгуур, үзүүлэлтүүд, баримт мэдээ цуглуулах арга замын талаар мэдээлнэ. Энэ бүлэг нь бүхэлдээ үнэлгээний багийн гишүүд, цэцэрлэгийн удирдлагад зориулагдсан бөгөөд цэцэрлэгийн өөрийн үнэлгээний таван үндсэн чиглэл (үр дүнд тулгуурласан менежмент, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, түүний чанар, хүүхдэд ээлтэй орчин, гэр бүл, олон нийтийн оролцоо), тэдгээр чиглэлийн хүрээнд чухам юуг, ямар шалгуураар шинжих, ямар үзүүлэлтээр хэмжих, үнэлгээний баримт, мэдээг хэнээс, ямар арга замаар цуглувуж болохыг хүснэгтээс харж болно. Үнэлгээний багийн гишүүн бүр (ямар чиглэлийг хариуцаж авснаас үл хамааран) цэцэрлэгийн хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэх бүх чиглэл, агуулгын хүрээ, үнэлэх шалгуур, үзүүлэлт бүрийг нухацтай уншиж, судалсны дараа багийн уулзалт, ярилцлага зохион байгуулах хэрэгтэй. Энэхүү уулзалт ярилцлага нь үнэлгээний багийн гишүүд ойлголтын зөрөөгүй ажлаа эхлэхэд төдийгүй үнэлгээг олон талаас харж хийхэд тус болно. Тухайн орон нутаг, цэцэрлэгийн нөхцөл байдлаас хамааран зарим шалгуур, үзүүлэлтийг өөрчлөх, хасах, нэмэх эсэхийг үнэлгээний багаар ярилцаж шийднэ.

Хоёрдугаар бүлэг нь үнэлгээний баримт мэдээ цуглуулахад ашиглах хэрэгслээс бүрдэнэ. Цэцэрлэгийн үйлчилгээний үр шимийг хүртэгч хүүхдүүд, тэдний сэтгэл ханамжийг илэрхийлэх зорилтот бүлэг бол эцэг эх, асран хамгаалагчид мөн. Иймд эцэг эх бол энэхүү судалгааны үнэ цэнэтэй оролцогчид төдийгүй бас үнэлгээний үр шимийг хүртэгч бүлэг юм. Тухайн цэцэрлэгт хоёроос доошгүй жил хүмүүжсэн хүүхдүүдийн ээж, аав, асран хамгаалагчдаар үнэлгээний хуудсыг бөглүүлнэ. Тэгэхдээ миний хүүхдийн хөгжил, аюулгүй байдал ба хамгаалал, миний хүүхдийн эрүүл мэнд, суралцаж хөгжих

орчин гэсэн хэсгийг тус тус бөглөж үнэлэхийн зэрэгцээ эцэг эх бас цэцэрлэгийн үйл ажиллагаанд хэр оролцдог болохоо өөрөө үнэлнэ. Эдгээр дэд хэсгүүд нь үнэлгээний чиглэл, агуулгын хүрээ бүрд эй үг, үсэг дараалан тохирохгүй ч өгсөн мэдээлэл бүрийг шалгур, үзүүлэлтүүдэд харгалзуулж боловсруулсныг үнэлгээний багийн гишүүдэд зориулсан матрицын хуудаснаас харж болно. Эцэг эхийн үнэлгээний хуудасны төгсгөлд байгаа “Миний санал” хэсэгт зургаан нээлттэй асуултад хариулж бичих хангалттай хугацаа өгч, эцэг эх нэг бүрийн санал цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулахад үнэ цэнэтэй гэдгийг судалгааны явцад сануулж, зөвлөх хэрэгтэй.

Эцэг эхээр үнэлэх хуудсыг бөглүүлээд тухайн өдөртөө багтаан оролцогчдын үнэлгээний хуудас бүрд эй танилцаж, тодруулах шаардлагатай (дутуу орхисон, ойлгомжгүй, хангалтгүй, үгүй гэсэн хариултыг олон оролцогч сонгосон г.м) мэдээллийг асууж, ярилцахад бэлтгэнэ. Эцэг эхийн бүлэгтэй хийх ярилцлагад гарын авлага дахь асуултуудыг ашиглаж болох авч, шаардлагатай бол асуултуудыг өөрчилж болно. Үнэлгээнд оролцсон эцэг эхчүүдээс ярилцлагад оролцох боломжтой 8-12 эцэг эхийг урьж, бүлгийн ярилцлага зохион байгуулна. Үнэлгээний багийн нэг гишүүн (эцэг эхийн төлөөлөл байвал сайн) ярилцлагыг удирдаж, хоёр гишүүн тэмдэглэлийг хөтлөн (эсвэл бичлэг хийж болно), баримтжуулна. Бүлгийн ярилцлагын энэхүү баримтыг хожим үнэлгээний багийн гишүүд дүгнэлт гаргахдаа ашиглана.

Цэцэрлэгийн үндсэн сургалтанд хүүхэд нь хамрагдаагүй, сургуулийн өмнөх насын хүүхэдтэй эцэг эхийг баг, хорооны ажилтнуудтай хамтран сонгож, ганцаарчилсан ярилцлага хийнэ. Энэ хэсэгт хүүхэд нь цэцэрлэгийн хувилбарт сургалтад хамрагдаж байгаа, алслагдсан нутгийн, эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, тухайн орон нутагт шинээр суурьшсан, хүүхэд нь цэцэрлэгт хамрагдаж чадаагүй эцэг эхийн төлөөлөлтэй ярилцахыг хичээнэ. Ганцаарчилсан ярилцлагын жишиг асуултуудыг гарын авлагын уг бүлгээс авч ашиглаж болох ч орон нутгийн онцлогт нийцүүлэн өөрчилж болно.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг үзүүлж буй гол субъект нь багш нар билээ. Иймд үнэлгээний хэрэгслийн дараагийн хэсгийг багш нарт зориулсан. Юуны өмнө, судалгаанд хамрагдсан эцэг, эхчүүдийн хүүхдүүдтэй ажиллаж буй багш нар, боломжтой бол бусад багш, туслах багш нараар үнэлгээний хуудсыг бөглүүлж, өөрийн үнэлгээ хийлгэнэ. Үнэлгээний багийн гишүүд оролцогчдын хуудас нэг бүрд эй танилцаж, тодруулах шаардлагатай мэдээллийн жагсаалтыг гаргана. Багийн зарим гишүүд багш нарын хичээлд сууж, ажиглалт хийнэ. Ажиглалтын тэмдэглэл хийх хуудсыг гарын авлагын хоёрдугаар бүлгээс авч ашиглах бөгөөд ажиглах зүйлийг цэцэрлэгийнхээ нөхцөл байдалд тохируулан өөрчилж болно.

Танхимд хийсэн ажиглалтын дараа багшийн хөтөлдөг баримт бичгүүдтэй танилцаж, ярилцана. Хичээлд суух болон баримт бичигтэй танилцахын өмнө багшаас асууж, зөвшөөрөл авч, ойлголцсон байх ёстойг анхаарна уу. Багшийн хөтөлдөг баримт бичигтэй танилцах, дүн шинжилгээ хийхэд ашиглах хуудсыг гарын авлагын мөнхүү бүлгээс авч ашиглах боловч баримт бичгээс тодруулах зүйлд үнэлгээний баг өөрчлөлт оруулж болно. Баримт бичигтэй танилцахдаа багшийн ярьж, танилцуулж, үзүүлж харуулж буй зүйлийг анхааралтай сонсож, ажиглан, тэмдэглэл хийнэ. Энэ нь “баримт бичгийн шалгалт” бус баримт мэдээ цуглуулж буй үйл явц гэдгийг мартаж болохгүй.

Дээр дурдсан багшийн үнэлгээний хуудсанд хийсэн анализаас тодруулах мэдээллийн

жагсаалт, хичээлийн ажиглалтын тэмдэглэл, багшийн хөтөлдөг баримт бичгийн шинжилгээ зэргийн эхний үр дунд тулгуурлан багш нарын бүлэгтэй ярилцлага хийнэ. Бүлгийн ярилцлагад 5-7 багшийг хамруулж, зарим мэдээллийг тодруулж, цэцэрлэгийн үйл ажиллагааны дараагийн шатны төлөвлөлтийг хийхэд анхаарах зүйлсийг тодорхой болгоход чиглэвэл зохистой.

Цэцэрлэгийн хүүхэд бүрд ээлтэй бодлого, түүнийг хэрэгжүүлэх ажилд манлайлажид нь цэцэрлэгийн удирдах ажилтнууд билээ. Цэцэрлэгийн үйл ажиллагааны доголдол, дутагдал бурийг мэдэхийг хүсдэг, бас засаж залруулахыг эрмэлздэг цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчид, цэцэрлэгийн удирдах зөвлөлийн гишүүд нь үнэлгээний үр дүнг сонирхогч идэвхтэй бүлэг мөн. Ийм ч учраас тэд энэхүү өөрийн үнэлгээг үр дүнтэй хийхэд дэмжлэг үзүүлж, манлайлж ажиллах болно.

Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчээр үнэлгээний хуудсыг бөглүүлсний дараа цэцэрлэгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны хэрэгжилтийн баримт бичгүүд, тайлантай танилцаж, цэцэрлэгийн орчинд ажиглалт хийнэ. Ажиглалтын тэмдэглэл хийх загварыг гарын авлагаас авч ашиглах боломжтой ч нөхцөл байдалдаа тохируулан ажиглах зүйлс, тэмдэглэл хөтлөх хүснэгтийг өөрчилж болно. Үнэлгээний хуудас, баримт бичгийн анализ, ажиглалтын тэмдэглэлд үндэслэн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчээс тодруулах зүйлийг асууж, ярилцана. Энэхүү ганцаарчилсан ярилцлагын чиглэл, жишиг асуултуудыг гарын авлагын хоёрдугаар бүлгээс хараарай. Мөн цэцэрлэгийн эрхлэгчтэй ганцаарчилсан ярилцлага хийх бөгөөд ярилцлагын удирдамжийг гарын авлагын хоёрдугаар бүлгийн найм дахь зүйлээс авч ашиглаарай.

Цэцэрлэг хүүхдэд ээлтэй орон нутгийг хөгжүүлэхэд хэр манлайлж ажиллаж буйг бодитой үнэлэх, цаашид орон нутгийнхаа дэмжлэгийг авч хамтран ажиллахад үнэтэй санаа бодлоо хуваалцах субъект бол сум, баг, хорооны засаг дарга хийгээд засаг даргын газрын ажилтнууд юм. Энэ үүднээс орон нутгийн удирдлагаар үнэлгээний хуудсыг бөглүүлж, ганцаарчилсан ярилцлага хийнэ. Ярилцлагын удирдамжийг энэ булгийн төгстөлийн хэсгээс үзнэ үү.

Ийнхүү үнэлгээнд оролцох гол хүмүүсээс мэдээлэл цуглуулж дуусаад, үнэлгээний багийн гишүүд судалгааны баримт материалд боловсруулалт хийх ажлыг хамтран гүйцэтгэнэ. Тэгэхдээ үнэлгээний багийн гишүүдэд зориулсан “Үнэлгээний шалтуур үзүүлэлтүүд ба хэрэгслийн хамаарлын матрицын хуудас”, “cfkgi.blog.gogo.mn” блог болон “www.cfkgi.net” сайт дахь “ХЭЦ-ийн өөрийн үнэлгээ” цэсний боловсруулалтын (data processing) хэсгийг ашиглана. Блогт байрлуулсан Excel файлыг татаж авсны дараа, үнэлгээний баримт мэдээг зааврын дагуу шивж оруулна. Үнэлгээнд оролцсон субъект (эцэг эх, багш, цэцэрлэг, орон нутгийн удирдлага) бурийн хариулт буюу баримт (data)-ыг өөр өөр хуудсанд (sheet) шивэхээр зохион байгуулсныг анхаараарай. Мөн оролцогчдын “Тийм” хариултыг (бидний хэрэгсэлд инээмсэглэж буй нүүрний зурагтай) “Хангалттай” баганад; харин “Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай” (ердийн нүүр), “Үгүй” (ууртай нүүр) гэсэн хариултуудыг “Хангалтгүй” баганад шивж оруулахдаа зөвхөн “1” тоогоор тэмдэглэнэ. Энэ нь боловсруулалтын төгсгөлд дунг нэгтгэх процесстий холбоотойг блогт тайлбарласан байгаа. Үнэлгээний багана бурийг өөр өнгөөр ялгаж байгаа нь шивэлтийн явцад техник алдаа гарахаас сэргийлж буй хэрэг юм. Боловсруулалт хийсний дараа багийн гишүүд “Үнэлгээний багийн ажлын хуудас” хэсгийг дарааллын дагуу бөглөж, дүгнэлт, санал зөвлөмжөө үнэлгээ хийсэн чиглэл, агуулгын хүрээ, шалгуур бүрээр бичнэ. Үнэлгээний багийн ажлын хуудсанд

субъект бүрийн (эцэг эх, багш, цэцэрлэг, орон нутгийн удирдлага г.м) үнэлгээний үр дүнг нэгтгэн дүгнэнэ.

Гуравдугаар бүлгийг цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг болон менежментийн багийн гишүүдэд зориулсан болно. Өмнөх бүлэгт зөвлөсөн аргачлалын дагуу хийсэн өөрийн үнэлгээнд тулгуурлан, танай цэцэрлэгийн үйлчилгээний үр шимийг хүртэгч хүүхдүүдийн эцэг эх, орон нутаг, олон нийтийн төлөөлөл, үйлчилгээ үзүүлэгч багш, ажилтнууд, удирдлага зэрэг олон талын оролцоотойгоор төлөвлөлтийг хэрхэн хийх арга зүйг ойлгоход энэ бүлэг туслах болно. Төлөвлөлтийг хийх есөн алхмыг ашиглахыг санал болгохын зэрэгцээ цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөөний эхний хувилбараа оролцогчдоор үнэлүүлэх, уг үнэлгээний үр дүнд тулгуурлан сайжруулж, дахин боловсруулах талаар зөвлөсөн буйгanzaарна уу. Цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ явцын үнэлгээ, хяналт шинжилгээг хэрхэн хийх, явцын үнэлгээ болон төлөвлөгөөний үр нөлөөг үнэлэх жишиг асуулга, хийсэн ажлаа үнэлж, цэгнэн, хурсэн амжилтаа тэмдэглэх санааг энэ хэсгээс авах боломжтой.

Эцэст нь тэмдэглэхэд, цэцэрлэгийн өөрийн үнэлгээнд тулгуурласан, олон талын оролцоотой төлөвлөлт, түүний хэрэгжилт, хяналт шинжилгээ, засан сайжруулах, дахин төлөвлөх үйл явц нь хүүхдэд ээлтэй болохын төлөө ажиллаж буй танай байгууллагыг тасралтгүй хөгжилд хөтлөх болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд

1.1. Байгууллагын өөрийн үнэлгээний тухай ойлголт

Монгол хэлний тайлбар тольд “үнэлэх” хэмээх үгийн утгыг “юмны зэрэг, хэрийг тогтоох”⁹ гэсэн утгатай хэмээн тайлбарлажээ. Энэхүү үгийн утгаас харвал, үнэлэх гэдэг нь үнэлж буй зүйлийг харьцуулан жишиж үзэх замаар хэр зэргийг шинжлэн тогтоох үйл аж.

Үнэлгээ, хяналт шинжилгээний мэргэжилтнүүд ч хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний үйл ажиллагааны явцын хийгээд хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор тодорхой арга зүйгээр хийж буй системтэй үйл ажиллагааг үнэлгээ гэж тодорхойлсон байх нь түгээмэл. Гэсэн хэдий ч аливаа үнэлгээ нь мэдээллийг системтэй цуглуулж, түүндээ шинжилгээ хийх ба дүгнэлт гаргах үйлийг заавал гүйцэтгэдэг болохыг онцолсон байдаг.

Үнэлгээ нь улс орон, орон нутаг, салбарын, эсвэл байгууллагын хэмжээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйлчилгээ (жишээ нь, сургуулийн өмнөх боловсролын) нь бодлогын тодорхой зорилготой (жишээ нь, бага насын хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах) хэр нийцэж буйг болон хөтөлбөр, үйл ажиллагааг хэрхэн хэрэгжиж, зорилтот бүлэгт (сургуулийн өмнөх насын хүүхдүүдэд) хэр хүрч байгааг тогтоохос гадна үр өгөөжийг сайжруулахын тулд ямар өөрчлөлт хийх шаардлагатайг тодруулдаг. Түүнчлэн үнэлгээ нь тухайн үйл ажиллагаа, арга замыг дэмжих, үл дэмжих нотолгоо гаргахын зэрэгцээ, ажил тогтвортой үргэлжлэх нөхцлийг хангах, өргөжүүлэх, эсвэл хязгаарлах, төсвийг нэмэгдүүлэх, эсэх зэрэгт нөлөөлдөг.

Цэцэрлэгийн өөрийн үнэлгээ нь цэцэрлэгийг хүүхэд бүрдээлтэй байдлаар хөгжүүлэхийн тулд зорилго, зорилтоо хэрхэн тодорхойлж, ямар үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тухайн орон нутгийн сургуулийн өмнөх насын хүүхдүүдэд үр өгөөжтэй байгаа эсэх, туршлага, сургамждаа тулгуурлан үйл ажиллагааг цаашид хэрхэн засаж, сайжруулах, ажлын арга хэлбэрээ хэрхэн өөрчлөх зэрэг олон асуултад хариулт өгч, шийдэл гаргахад туслах хүчтэй хэрэглүүр юм. Ийнхүү үнэлгээний тусламжтайгаар цэцэрлэг гарсан ахиц өөрчлөлт, ололт амжилт, бэрхшээл хүндрэлээ тодорхойлж, бага насын хүүхдийн суралцах, хөгжих үйл явцын чанарыг сайжруулах оновчтой бодлого, хөтөлбөр боловсруулж, үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлнэ. Хэдийгээр үнэлгээ дангаараа асуудлыг шийдвэрлэх арга, хэрэглүүр болж чадахгүй ч нөхцөл байдалд нөлөөлж буй шалтгаан, үр дагаврыг судлан шинжлэх үйл явц учраас ажлыг сайжруулах, шинэчлэх боломж олгодогт түүний ач холбогдол оршино.

Тухайн байгууллагын үнэлгээ хийх зорилгоос хамаарч үнэлгээнд ашиглах судалгааны арга, хэрэгсэл, шинжих шалгуур, хэмжих үзүүлэлтүүдийг тодорхойлно. Юуг, яаж үнэлэх асуудлыг тодорхой болгохын тулд үнэлгээний чиглэл, агуулгын хүрээг нарийвчлан тодорхойлж, үнэлгээ хийхэд ашиглах арга, хэрэгслээ боловсруулах учиртай.

Энэ бүлгийн дараагийн хэсэгт танилцуулах үнэлгээний чиглэлүүд, чиглэл тус

9 Цэвэл Я., “Монгол хэлний төвч тайлбар толь”, Уб., 1966, х. 623.

бүрийн агуулгын хүрээг сонгохдоо хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үзэл санааны үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд/чиглэлүүд (бага насны хүүхэд бүрд сургуулийн өмнөх боловсрол эзэмших боломжийг адил тэгш олгох, хүүхдүүд эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчинд суралцаж, хөгжих, цэцэрлэгийн хүүхэд төвтэй бодлого, үйл ажиллагаанд гэр бүл, олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх)-ийг баримжаалсан болно.

Үнэлгээг түүний зорилго, төвлөрч дүн шинжилгээ хийж буй зүйлд нь үндэслэн хэрэгцээний (needs assessment), үйл явцын (process analysis), үр дүнгийн (outcome analysis), зардал үр ашгийн (efficiency analysis) гэж ангилдаг. Байгууллагын ялангуяа хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээ нь үйл явцыг үнэлэхийг шаарддаг. Хүүхдэд ээлтэй орон нутаг, байгууллагыг (сургууль, цэцэрлэг) үнэлж буй бусад орны туршлага ч энэ хандлага руу чиглэж байна. Учир нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үнэлгээг нэг удаа хийснээр “хүүхдэд ээлтэй цэцэрлэг” болчихно гэж ойлгож болохгүй бөгөөд “хүүхдэд ээлтэй байдал”-ыг бий болгон, хөгжүүлэх нь тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Нөгөө талаас, өөрийн үнэлгээ нь байгууллагын тасралтгүй хөгжлийн үндэс билээ. Иймд бидний үнэлэх зүйл бол цэцэрлэгийн үйл ажиллагаа, менежмент байх болно.

Менежмент

Байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээнд гарч буй нэг гол өөрчлөлт нь хэрэгжилтэд анхаарсан уламжлалт хандлагаас татгалзаж, үр дүнд суурилсан шинэ хандлага руу шилжиж байна. Өөрөөр хэлбэл, байгууллага төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлсэн боловч, үнэхээр бодитой, хүсэн хүлээж байсан үр дүнг буй болгож чадсан уу гэсэн асуултад байгууллагын өөрийн үнэлгээ хариулт өгөх шаардлагатай болж байна. Байгууллага өөрийн үйлчлүүлэгч, түншүүддээ амласан амлалтаа үнэхээр биелүүлж чадсан уу? Манай жишээн дээр бол хүүхдүүд, тэдний эцэг эх, нутгийн олон нийтэд амласан зүйлээ биелүүлж чадсан уу? “Үр дүн нь юу болов?” гэсэн асуултад хариулах, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг шууд (хүүхэд, эцэг эх) ба дам (нутгийн олон нийт, татвар төлөгчид) хүртэгч олноос тавьж буй, улам бүр хүчтэй болж байгаа үр дүнгийн төлөөх шаардлагад хариулт өгөхийн тулд байгууллагын үр дүнд тулгуурласан менежментийг үнэлэх хэрэгтэй болж байна. Үнэлгээний судалгаагаар төрөлжсөн дэлхийн нэр хүндтэй байгууллагуудын (McKinsey гэх мэтийн) туршлагаас хараад, байгууллагын үр дүнд тулгуурласан менежментийг үнэлэхдээ байгууллагын хүсч тэмүүлж буй зүйл буюу эрхэм зорилго, алсын хараа, стратеги, төлөвлөлт, гүйцэтгэлийн менежмент, хүний нөөцийн төлөвлөлт ба хөгжил, байгууллагын болон ажилтнуудын манлайлал¹⁰ зэрэг элементүүдийг авч үзсэн байдал. Бид ч хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үр дүнд тулгуурласан менежментийг үнэлэх агуулгын хүрээг тогтооходоо энэхүү туршлагыг ашигласан болно.

СӨБ-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний хоёр дахь чиглэл нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний **хүртээмж** юм. Энэ чиглэлийн хүрээнд үнэлэх гол зүйл нь тэгш хамрахуй тул агуулгын хүрээ нь тэгш байдал, хамран сургалтаас бүрдэнэ.

Тэгш хамрахуйг яагаад үнэлэх хэрэгтэй вэ? Бүх хүүхэд боловсрол эзэмших эрхтэй. Хүүхдийн эрхийн конвенцид, “хүүхэд бүр анхан шатны боловсролыг үнэ төлбөргүй

эзэмших эрхтэй бөгөөд ... боловсрол хүүхэд бүрд хүртээмжтэй байх ёстой”¹¹-гэж заасан билээ. Энэ эрхээ эдлэхэд тухайн хүүхдийн сургуульд хэрхэн бэлтгэгдсэн байдал онцгой нөлөө үзүүлдэг. Иймд цэцэрлэг нь хүүхэд нэг бүрд, ялангуяа эрсдэлтэй нөхцөлд байгаа болон эмзэг бүлгийн (алслагдсан нутгийн, шилжин ирсэн, хэл, соёлын ялгаатай, хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эхийн анхаарал халамж сул г.м) хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролыг ялгаваргүй, адил тэгш нөхцөл боломжтойгоор эзэмшүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл, хүүхэд нэг бүрийг нас, хүйс, бие бялдар, оюун ухаан, нийгмийн байдал, сэтгэц, хэл яриа бусад зүйлээр алагчлан ялгаварлахгүйгээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд тэгш хамарна гэсэн үг.

Тэгш хамрах гэдэг нь нэгтгэх (интеграцилах)-ээс илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хамрах нь нэгтгэж буй жишээ мөн. Харин тухайн хүүхэд цэцэрлэгтээ үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа тоглож, хөгжих боломжтой, багш нь хүүхдийн хөгжлийн онцлог хэрэгцээнд нийцсэн хувилбарт хөтөлбөртэй, эцэг, эхэд нь тусалж зөвлөдөг бол тэгш хамарч буй хэрэг юм.

Тэгш хамрах нь хэнд хэрэгтэй вэ? Тэгш буюу бүгдийг (*inclusive*) хамрах нь бүгдэд, бүх талуудад ашигтай. Жишээ нь, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд цэцэрлэгт хамрагдсанаар үе тэнгийнхээ бусад хүүхэдтэй харилцах, хөгжих боломж олдож, улмаар гэр бүл, нийгмийн амьдралд оролцож, цаашид амжилттай суралцах боломжтой болно. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өдөр бүр харилцаж, тоглож буй үе тэнгийн бусад хүүхдэд ч ашигтай. Учир нь тэд бусдын боломж, чадавхийг үнэлж, хүндэтгэж, онцлогийг ойлгож, бас хүлээлтэй байж сурна. Багаасаа тэгш хамрах сургалтын үр шимийг хүртсэн хүүхэд хожим эрх тэгш нийгмийг байгуулах, тэгш байдлын төлөө тэмцдэг иргэн болно. Уг хүүхэдтэй ажиллаж буй багшийн хувьд хөгжлийн ялгаатай хүүхэдтэй, тэдний гэр бүлтэй ажиллах, сургалтын болон хөгжүүлэх ажлыг уян хатан төлөвлөх, зохион явуулах ур чадвар нь бусад багштай харьцуулахад илүү хөгжиж, туршлага хуримтлуулах давуу талтай. Ийм учраас тэгш хамралтыг үнэлэх шаардлагатай.

СӨБ-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Цэцэрлэгийн өөрийн үнэлгээний гурав дахь чиглэл нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар юм. Аливаа байгууллага өөрийн үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн байнгын эрэл хайгуул, оролдлогын үр дүнд байгууллагаа системтэй хөгжүүлдэг. Ер нь чанар гэдэг нь “шаардлагад нийцсэн байж” гэсэн утгатай. Манай жишээн дээр, энэхүү шаардлага нь нийгмийн хүлээлтийг төлөөлөх бага насны хүүхдийн хөгжлийн стандарт, үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангаж буй байдлыг илэрхийлэх эцэг, эхийн сэтгэл ханамж, цэцэрлэгийн эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний баталгаатай байдлаар тодорхойлогдоно. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний үр шимийг хүртэгч хүүхэд бүрд эй ойр дотно ажилладаг хүмүүс нь цэцэрлэгийн багш нар билээ. Боловсролын үйлчилгээний чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйлийн нэг нь багш, сурагчдын харилцаа байдгийг хүүхдэд ээлтэй сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн улс орнуудын туршлага харуулсан байdag. Иймд багш, хүүхдийн харилцааг энэ чиглэлийг үнэлэх агуулгын хүрээнд багтаасан болно.

Бага насны хүүхдийн тухайд эрүүл мэнд, хоол хүнс, холбогдох үйлчилгээ чухал ач холбогдолтой байдгийн хувьд энэ нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний

11 Хүүхдийн эрхийн тухай конвенц, 28-р зүйл.

чанарыг тодорхойлох нэг бүрдэл хэсэг болно. Хоол хүнс хангалтгүй байх, шаардлагатай амин дэм, эрдэс бодисын дутагдал нь бага насын хүүхдүүдийг илүү өвчлөмтгий, эмзэг болгож, улмаар бие махбодь, оюуны хөгжлийн бэрхшээлтэй байдалд хүргэж болзошгүй юм. А аминдэмийн дутагдлаас болж жил тутам 250 000 – 500 000 хүүхэд хараагүй болох эрсдэл байгааг¹² судлаачид анхааруулсан байдаг. Бага насын тэжээлийн дутагдал, үргэлжилсэн суулгальт нь хүүхдийг тухайн насандаа тохирох жинд хүрэхгүй, тураалд ороход хүргэх төдийгүй танин мэдэхүйн хөгжилд нь сөрөг нөлөө үзүүлж, насан туршид нь сөргөөр нөлөөлөхийг үгүйсгэхгүй.

Хүүхдэд ээлтэй орчин бүрдэлт

Амьд бүхэнд үйлэнд суралцаж, тэрхүү үйлийг амьдарч буй орчин нь төрүүлдэг жамтай. Хүүхдийн, ер нь хүний юунд, хэрхэн суралцахад нь орчин нөлөөлдөг. Иймд хүүхдийн цэцэрлэг нь хүүхдүүдийн юу хүсч байгаа болон тэд юуг, ямар тувшинд сурах шаардлагатайд тохирсон орчныг бүрдүүлэх хэрэгтэй болж байна. Хүүхдийн хөгжилд эрүүл мэндийн байдал, хоол тэжээл, аюулгүй, хамгаалагдсан орчин шууд нөлөөлдөг. Хүүхэд аюулгүй, ая тухтай байдлыг мэдэрч буй үедээ сурах, хөгжих боломжийг бүрэн ашиглаж чаддаг¹³ гэдгийг “Эрүүл, хамгаалагдсан сургууль” хөтөлбөр (school health and safety program)-т хамрагдсан Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгийн орнуудын олон сургуулийн туршилт нотолсон байдаг. Иймд бага насын хүүхэд бүрд ээлтэй орчинг хэр бүрдүүлж буйг үнэлэх нь цэцэрлэгийн өөрийн үнэлгээний дөрөв дэх чиглэл юм. Хүүхэд бүрд гэдгийн цаана орчны тэгш, хүртээмжтэй байдлыг ойлгоно. Хүүхдүүд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бие засах газрын хүртээмжгүй байдлаас шалтгаалан бие засах давтамжаа цөөрүүлэхийн тулд идэж, уухаа багасгаж, энэ нь хоол тэжээл, хэвийн өсөлтөд серөг нөлөө үзүүлж¹⁴ байгааг судлаачид анхааруулсан байдаг. Иймд тэгш, хүртээмжтэй, хүйсийн мэдрэмжтэй, эрүүл, аюулгүй орчин нь хүүхэд хэвийн өсч хөгжих ээлтэй орчныг үнэлэх хүрээ болж байгаа юм.

Гэр бүл, олон нийтийн оролцоо

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн нэгэн зорилго нь эцэг эх, олон нийтийн идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хүүхдийг “бүх талаас” нь дэмжин хөгжүүлэх явдал билээ. Цэцэрлэг нь гэр бүлд таатай сэтгэгдэл төрүүлэх болсон тэр цагт л хүүхдэд ээлтэй болж чадна. Хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь “дотно харилцаа нь нээлттэй, тодорхой байдлыг буй болгоно” гэсэн зарчмаар эцэг эхчүүдтэй ажиллана. Учир нь гэр бүл нь хүүхдийн хөгжлийн бүхий л ѿ шатанд тэдний хамгаалал, сайн сайхан байдалд хамгийн хүчтэй нөлөө үзүүлдэг. Цэцэрлэг гэр бүлтэй хамтран ажилласнаар хүүхдүүд ямар нөхцөлд амьдарч, хөгжиж байгааг мэдэх боломжтой. Багш нь хүүхдийн ар гэрийн нөхцөл байдал, онцлогийг сайн мэдэж байвал хүүхдийг илүү сайн ойлгож, түүний хэрэгцээнд нийцсэн, оновчтой арга барилыг сонгон ажиллах боломж бүрдэнэ. Багш нь хүүхдийн гэр булийн уламжлал, ёс заншил, үнэт зүйлсийг үл тоомсорлох нь багш – хүүхэд – эцэг эхийн хооронд үл ойлголцоо байдал, зөрчлийг буй болгож, хүүхэд цэцэрлэгтээ дургүй болоход хүргэж ч болзошгүй. Эцэг эхчүүдэд цэцэрлэгийн

12 “Эрүүл мэндийн тэгш үйлчилгээ” хэсэг, Дэлхийн хүүхдийн байдал 2013 тайлангийн хураангуй, НҮБ-ын Хүүхдийн сан, 7-р тал.

13 Creating a Healthy and Protective ILFE, UNESCO, 2005, р. 3.

14 “Эрүүл мэндийн тэгш үйлчилгээ” хэсэг, Дэлхийн хүүхдийн байдал 2013 тайлангийн хураангуй, НҮБ-ын Хүүхдийн сан, 8-р тал.

үүд хаалгыг нээж, тэдэнтэй хамтран ажилласнаар, хүүхэдтэй нь холбоотой асуудлыг хамтдаа шийдэж, эцэг эхчүүд гэртээ хүүхдийн сурч буй зүйлийг дадал хэвшил болоход нь тусалж, цэцэрлэгийн эрхэмлэх зүйлс, бодлого, үйл ажиллагааг бусдад ойлгуулан таниулахад дотны туслагч, бас сайн сурталчлагч болдог байна.

Цэцэрлэг нь хүүхдэд ээлтэй орон нутгийн нэгэн хэсэг мөн. Цэцэрлэгт явуулж буй сургалтын болон хөгжүүлэх ажлууд нь хүрээлэн буй орчин, нутаг оронтой харилцаа хамааралтай байдгийг өмнөх булэгт өгүүлсэн билээ. Хүүхдүүд зөвхөн цэцэрлэгээс бус тэднийг хүрээлэн байгаа хүмүүс, олон нийт, нийгмийн харилцаанаас суралцаж байдаг. Иймд цэцэрлэг, багш наарт туслах, хамтрыг хүссэн хүн бүр бидэнд тусалж чадна. Түүнчлэн хүүхдэд ээлтэй цэцэрлэг нь бага насын хүүхдийн халамж, хамгаалал, сайн сайхны төлөө бусад мэргэжлийн байгууллагатай, тухайлбал эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, халамжийн байгууллагатай харилцаа холбоотой ажиллах шаардлагатай байдаг. Бас орон нутгийнхаа засаг захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай ч хамтран ажиллах хэрэгцээ байна. Эдгээр байгууллагууд, гэр бүлтэй хамтран ажиллах нь цэцэрлэгийг хязгаарлагдмал нөөц, боломжкоосоо хамаарахгүйгээр хүүхдэд ээлтэй байх боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой. Энэхүү хамтын ажиллагаа, түншлэл нь цэцэрлэгийн дутууг нөхөж, хүүхдийн төлөө хамтдаа ажиллах үйл ажиллагаанд амжилт, үр нөлөөг авчрах учиртай. Ийм учраас гэр бүл, олон нийтийн оролцоо нь хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний тав дахь чиглэл болж байгаа юм.

1.2. Үнэлгээний чиглэл ба агуулгын хүрээ

Дээр өгүүлсэнтэй уялдуулан цэцэрлэгийн өөрийн үнэлгээний чиглэлүүд болон тэдгээрийн агуулгын хүрээг дараах байдлаар тодорхойлон гаргав.

Хүснэгт 1. Өөрийн үнэлгээний чиглэл ба агуулгын хүрээ

Чиглэл 1: Үр дүнд тулгуурласан менежмент 1.1. Зорилго 1.2. Бодлого, төлөвлөлт 1.3. Үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт, үнэлгээ 1.4. Хүний нөөцийн чадавх 1.5. Манлайлал	Чиглэл 2: СӨБ-ын үйлчилгээний хүртээмж 2.1. Тэгш байдал 2.2. Хамран сургалт
Чиглэл 3: СӨБ-ын үйлчилгээний чанар 3.1. Бага насын хүүхдийн хөгжлийн стандартын хэрэгжилт 3.2. Багш, хүүхдийн харилцаа 3.3. Эцэг эхийн сэтгэл ханамж 3.4. Цэцэрлэгийн эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний чанар	Чиглэл 4: Хүүхдэд ээлтэй орчин бүрдэлт 4.1. Эрх тэгш хүртээмжтэй орчин 4.2. Хүйсийн мэдрэмжтэй орчин 4.3. Эрүүл, аюулгүй хамгаалагдсан орчин
Чиглэл 5: Гэр бүл, олон нийтийн оролцоо	
5.1. Эрх тэгш оролцооны боломж 5.2. Гэр бүлийн оролцоо, хамтын ажиллагаа 5.3. Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа	

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд ба үнэлгээнд хэрэглэх арга, хэрэглүүр

Цэцэрлэгийн СӨБ-ын үйлчилгээ, үйл ажиллагааны хүүхдэд ээлтэй байдлыг үнэлэх үнэлгээний шалгуурууд болон тэдгээрийн үзүүлэлт, үнэлгээ хийх арга, хэрэглүүрийг

чиглэл бүрээр нь дараах хүснэгтэд харуулсан байдлаар боловсруулав.

Хүснэгт 2. ХЭЦ-ийн өөрийн үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд ба хэрэглэх арга, хэрэглүүр

Чиглэл 1: Үр дүнд тулгуурласан менежмент

Үнэлгээний шалгуур	Үнэлэх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Агуулгын хүрээ: 1.1. Зорилго		
I. Цэцэрлэгийн эрхэм зорилго, алсын хараа нь хүүхдийн эрхийн тухай конвенцийн үндсэн зарчмуудад тулгуурласан байдал	<ol style="list-style-type: none"> Эрхэм зорилго нь хүүхэд бүрд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх зарчимд тулгуурласан эсэх Алсын хараа нь бага насын хүүхдэд зориулсан халамж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн эсэх Цэцэрлэг нь хүүхэд бүрийн хувийн онцлог, хэрэгцээ, сонирхол; эцэг эх бүрийн санал хүсэлтэд хүндэтгэлтэй хандахыг өдөр тутмын үйл ажиллагаандaa эрхэмлэдэг эсэх Цэцэрлэг хэтийн зорилгодоо хүрэх дунд ба ойрын хугацааны тэргүүлэх зорилгыг дэвшүүлсэн эсэх Тэргүүлэх зорилгод хүрэх зорилтууд нь үр дүнг хэмжиж болохуйц, гүйцэтгэх цаг хугацааны хязгаартай, бүрэн томьёологдсон эсэх 	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн эрхэм зорилго, алсын хараа, тэргүүлэх зорилготой танилцаж, агуулгад нь анализ хийх Цэцэрлэгийн орчинд ажиглалт хийх Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч, багш нар, цэцэрлэгийн зөвлөлийн гишүүд, эцэг эхийн зөвлөлийн гишүүдтэй уулзаж ярилцах Цэцэрлэгийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцах
II. Цэцэрлэгийн дунд болон ойрын хугацааны зорилго нь түүний эрхэм зорилго, алсын хараатай уялдсан байдал		
Агуулгын хүрээ: 1.2. Бодлого, төлөвлөлт		
III. Цэцэрлэг нь хүүхдийг бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд учирч болох эрсдэлээс хамгаалсан бодлого баримталдаг байдал	<ol style="list-style-type: none"> Багш, ажилтнаас хүүхдийн биөд зохисгүй байдлаар хүрч, шийтгэл үзүүлэхийг хориглосон дүрэм журам мөрддөг эсэх Багш, ажилтан хүүхэдтэй харилцаж байхдаа болон ойр орчинд нь бүдүүлэг үг хэллэг хэлэх, зүй бус үйлдэл хийх, хашхирч зандрахыг хориглосон журам мөрддөг эсэх Аливаа ялгаварлан гадуурхах (хүйс, хэл, соёл, нийгмийн байдал г.м) үзэгдлийг хориглосон журам мөрддөг эсэх Хүүхдийн эрүүл мэнд, хоол хүнсний цогц үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг тодорхой төлөвлөдөг эсэх Аюулгүй байдлын дүрмийг мөрддөг эсэх 	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн бодлогын баримт бичгүүдтэй танилцах Хамран сургах тойргийн хүүхдийн СӨБ-д хамралтын судалгаа Цэцэрлэгээс хийсэн судалгааны тайлланг уншиж судлах Цэцэрлэгийн стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй танилцах

<p>IV. Цэцэрлэг нь бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах бодлого баримталдаг эсэх</p>	<p>11. Үйл ажиллагааны төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээнд үндэсний цөөнх, эмзэг булгийн (хөгжлийн бэрхшээлтэй, алслагдсан нутгийн, ядуу өрхийн г.м) хүүхдийн асуудлыг тодруулан авч үзсэн эсэх</p> <p>12. Хүүхдэд ээлтэй боловсролыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаандaa мөрддөг дүрэм журам нь бүх эцэг эх, ялангуяа үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй, ядуу амьдралтай, алслагдсан нутагт оршин суудаг (нүүдэлч малчин), шилжин ирсэн эцэг эхэд нээлттэй, ойлгомжтой, хүртээмжтэй байдаг эсэх</p> <p>13. Хамрануйлчлэхтойргийнхаосургуулийн өмнөх насны бүх хүүхдийн (цэцэрлэгт хамрагдсан болон хамрагдаагүй) дэлгэрэнгүй бүрд гэл-судалгаатай эсэх</p> <p>14. Бүх хүүхдийг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, алслагдсан нутгийн, ядуу өрхийн хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулахад тохиолдож буй саад бэрхшээлийг тодруулсан эсэх</p>	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, эмч, багш нар, цэцэрлэгийн зөвлөлийн гишүүд, эцэг эхийн зөвлөлийн гишүүдтэй уулзаж ярилцах Цэцэрлэгийн үндсэн ба хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдүүдийн бүрд гэлтэй танилцах
<p>V. Цэцэрлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв нь гүйцэтгэлд төвлөрсөн байдал</p>	<p>15. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь үйлчилгээнийхээ хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн эсэх</p> <p>16. Үйл ажиллагааны төлөвлөгөө нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн байдал</p> <p>17. Үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг боловсруулахад хамтын оролцоо, нээлттэй байдлыг хангадаг эсэх</p> <p>18. Төсвийг үр ашигтай зарцуулдаг эсэх</p>	
<p>Агуулгын хүрээ: 1.3. Үйл ажиллагааны хэрэгжилт, хяналт, үнэлгээ</p>	<p>VI. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл</p>	<p>19. Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг мэдээлж, хэлэлцдэг байдал</p> <p>20. Цэцэрлэгт бүх хүүхдийг тэгш хамрах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлдэг эсэх</p>

VII. Үр дүнд сууриссан хяналт шинжилгээ, үнэлгээний механизм бүрдсэн байдал	<p>21. Үйл ажиллагаандаа байнгын, төлөвлөгөөт хяналт шинжилгээ, өөрийн үнэлгээ хийдэг эсэх</p> <p>22. Багш, ажилтнуудтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, үнэлдэг эсэх</p> <p>23. Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, явцын үнэлгээг тогтмол хийдэг эсэх</p> <p>24. Цэцэрлэгээс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үр нөлөөг хэмжиж, үнэлдэг эсэх</p> <p>25. Үнэлгээний үр дүнг ил тод илтгэж, тайлагнадаг эсэх</p> <p>26. Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнд тулгуурлан үйл ажиллагааны ба стратеги төлөвлөлтөд өөрчлөлт оруулдаг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэг хүүхдэд ээлтэй байдлаа үнэлсэн өөрийн үнэлгээний тайлантай танилцах • Тайлангийн хурлын тэмдэглэлд анализ хийх
---	---	--

Агуулгын хүрээ: 1.4. Хүний нөөцийн чадавх

VIII. Боловсон хүчиний хангалт	<p>27. Мэргэжлийн багш (хөгжмийн болон биеийн тамирын багш), туслах багш хангалттай эсэх</p> <p>28. Мэргэжлийн тогooчтой эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хавсралт • Багш, ажиллагсдын дунд зохион байгуулсан уулзалт, ярилцлага, семинар, хурлын тэмдэглэл
IX. Багш, ажилтнуудын хүүхдэд ээлтэй боловсролын талаарх мэдлэг, ойлголт	<p>29. Ажилтан бүр хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын бодлого болон эрх зүйн үндсэн баримт бичгүүдийг хангалттай судалсан эсэх</p> <p>30. Багш, ажилчдын ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын бодлогын заалтуудыг тусгадаг эсэх</p> <p>31. Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг дэмжих нөхцөл бололцоо, эх үүсвэрийн талаар хангалттай мэдлэгтэй эсэх</p> <p>32. Багш нар хүүхдэд бие бялдар, сэтгэл санаа, хөгжлийн бэрхшээл үүсгэдэг өвчин, халдварт өвчиний талаар хангалттай мэддэг эсэх</p> <p>33. Багш, ажилчид хүүхэд, эцэг эхийн өмнө хүлээх үүрэг хариуцлагаа хангалттай мэддэг эсэх</p> <p>34. Багш нар багшийн ёс дүрмээ мөрддөг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш нараас авах асуулга, ярилцлага

<p>Х. Багш, ажилтнуудын хүүхдэд ээлтэй үйлчилгээ үзүүлэх ур чадвар</p> <p>XI. Цэцэрлэгийн багш, ажилтнуудын хандлага</p>	<p>35. Багш, ажилтнууд хүүхэд, эцэг эхийг анхааралтай сонсож чаддаг эсэх</p> <p>36. Багш, ажилтнууд эцэг эх, асран хамгаалагчтай идэвхтэй харилцдаг эсэх (харилцаа тогтоох, хадгалах, татан оролцуулах)</p> <p>37. Багш, ажилтнууд багаар хамтарч ажиллах чадвартай эсэх</p> <p>38. Багш, ажилтнууд бага насын хүүхдийн эрх ашигийн төлөө ажиллаж буй хүмүүс (бусад багш нар, олон нийтийн төлөөлөл)-ийг манлайлах чадвартай эсэх</p> <p>39. Багш нар хүүхэд нэг бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулж чаддаг эсэх</p> <p>40. Багш нар суралцах тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах төлөвлөгөөг эцэг эх бусад хүмүүстэй (эмч, арга зүйч г.м) хамтран боловсруулж, ажилладаг эсэх</p> <p>41. Тэгш байдлыг эрхэмлэсэн, хүйсийн мэдрэмжтэй хэрэглэгдэхүүн (тоглоом наадгай, үзүүлэн, тараах материал г.м)-ийг бэлтгэж, сургалтын болон хөгжүүлэх үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг эсэх</p> <p>42. Багш, ажилчид хүүхдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай эсэх</p> <p>43. Багш, ажилтнууд өөрийгөө, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэн хүндэтгэж чаддаг эсэх</p> <p>44. Багш, ажилтнууд хүүхдүүд, тэдний эцэг эхийг хүндэтгэн харилцаж чаддаг эсэх</p> <p>45. Багш, ажилтнуудын ёс суртахуун хангалттай эсэх</p> <p>46. Багш, ажилтнууд ажилдаа хариуцлагатай, өөриймсөг ханддаг эсэх</p> <p>47. Багш, ажилтнууд хүүхдийн онцлог, ялгааг хүлээн зөвшөөрч, хүлээцтэй ханддаг эсэх</p> <p>48. Багш нь бүх хүүхэд (охид/хөвгүүд, ядуу өрхийн хүүхдүүд, алслагдсан нутгийн нүүдэлчин малчдын хүүхэд, өөр хэл, соёл, зан заншилтай үндэсний цөөнхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй) амжилттай сурч, хөгжиж чадна гэдэгт итгэдэг эсэх</p> <p>49. Багш, ажилтнууд бусдын (хүүхэд, эцэг эх, хамт ажиллаж буй хүмүүс г.м) нэр хүндийг хүндэтгэж чаддаг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхээс авсан сэтгэл ханамжийн судалгаа • Эцэг эхийн санал хүсэлтийн дэвтэр • Багш, ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан тухай мэдээ, тайланг судлах • Багш, ажилтнаас сорил авах • Багш, ажилтны үйл ажиллагаа, харилцаж буй байдалд ажиглалт хийх
--	--	--

XII. Багш, ажилтнуудын мэргэжил дээрээ хөгждөг байдал	50. Багш, туслах багш, цэцэрлэгийн бусад ажилтан (тогооч, эмч г.м)-үүд хүүхдэд ээлтэй суралцах орчин, тэгш хамран сургах чиглэлээр сургалт, туршлага судлах уулзалт, семинарт бүрэн хамрагдаж чадсан эсэх 51. Багш нар бага насын хүүхдийн хөгжил, төлөвшлийн асуудлаар байнга бие даан уншиж судалдаг эсэх 52. Багшнарсургуулийнөмнөхболовсролын үйлчилгээг хүүхдэд ээлтэй болгох чиглэлээр судалгааны ажилд оролцож, бүтээж түүрвих (бичиж боловсруулах, бүтээлийн сангaa баяжуулах, илтгэл тавих г.м) ажил хангалттай хийдэг эсэх	
Агуулгын хүрээ: 1.5. Манлайлал		
XIII. Орон нутгаа хүүхдэд ээлтэй хот, дүүрэг, сум, аймаг болоход оруулж буй хувь нэмэр ба нөлөөлөл	53. Бага насын хүүхдийн хөгжлийн чиглэлээр ажилладаг хамтарсан багтай эсэх 54. Багш, ажилтнууд орон нутгийн бага насын хүүхдийн хөгжил, хамгаалал, эрүүл мэндтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд хошуучилж оролцдог эсэх 55. Хүүхдэд ээлтэй боловсролын үзэл санааг орон нутагтаа түгээн дэлгэрүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүл, цэцэрлэгийг хөгжүүлэхэд бусад байгууллага, хүмүүст нөлөөлж чаддаг эсэх 56. Багш, ажилтнуудын дотор бага насын хүүхдэд бүрд СӨБ-ын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй чанартай хүргэх; гэр бүл олон нийттэй хамтарч ажиллах үйл хэргийг манлайлагчдын эзлэх хувь хангалттай эсэх	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн боловсрол соёлын газар, хэлтэс, хүүхдийн төлөө байгууллага, засаг захиргааны байгууллагын ажилтнуудтай ярилцах Цэцэрлэгийн зөвлөл болон багш ажилчдын хурлын тэмдэглэлтэй танилцах Цэцэрлэгийн үйл ажиллагааны ба өөрийн үнэлгээний тайланг судлах Эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөлтэй уулзаж ярилцах
XIV. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн хөгжилд үзүүлж буй дэмжлэг	57. Цэцэрлэг үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр санаачилгатай ажиллаж чадаж байгаа эсэх 58. Багш, ажилтнуудын тэгш хамран сургахуй, хүүхдийн эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчныг хөгжүүлэх чиглэлээр гаргасан шинэ санаачилга, бүтээлч үйл ажиллагааны түвшин хангалттай эсэх	

Чиглэл 2: Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж

Үнэлгээний шалгуур	Үнэлэх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Агуулгын хүрээ: 2.1. Тэгш байдал		
XV. Бүх хүүхэд сургуулийн өмнөх боловсролд тэгш хамрагдах нөхцөл бүрдүүлсэн байдал	<p>59. Бүх хүүхэд үйл ажиллагаанд хэл, соёл, хөгжлийн түвшин, хүйс, нийгэм эдийн засгийн байдал зэргээсээ үл хамааран адил тэгш оролцох боломжтой эсэх</p> <p>60. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эх нь багшаас туслалцаа, зөвлөгөө авах боломжтой эсэх</p> <p>61. Үндэсний цөөнхийн хэл дээр цэцэрлэгээс мэдээлэл, гарын авлага, зөвлөмж зэргийг боловсруулан гаргасан эсэх</p>	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас эрхлэн гаргасан мэдээлэл, цахим хуудас, үйл ажиллагааны тайлантай танилцах Цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан, өөрийн үнэлгээний тайланцад анализ хийх Эцэг эхэд зориулсан мэдээллийн самбар, хуудас, буланг ажиглах Цэцэрлэгийн урлаг, спортын арга хэмжээний дүрс бичлэг, холбогдох материалыг судлах Эцэг эх, орон нутгийн удирдлагаас асуулга авах
Агуулгын хүрээ: 2.2. Хамран сургалт		
XVI. Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байдал	<p>62. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдэд хүрч үйлчлэн, хамран сургалтыг нэмэгдүүлсэн эсэх</p> <p>63. Хувилбарт сургалтыг оновчтой, чанартай явуулсан эсэх</p>	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн засаг захиргааны байгууллагаас эрхлэн гаргасан мэдээлэл, цахим хуудас, үйл ажиллагааны тайлантай танилцах Цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан, өөрийн үнэлгээний тайланцад анализ хийх Эцэг эхэд зориулсан мэдээллийн самбар, хуудас, буланг ажиглах Эцэг эх, орон нутгийн иргэдээс асуулга авах

Чиглэл 3: СӨБ-ЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

Үнэлгээний шалгуур	Үнэлэх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Агуулгын хүрээ: 3.1. Бага насны хүүхдийн хөгжлийн стандартын хэрэгжилт		
XVII. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцэн хөтөлбөр боловсруулдаг байдал	<p>64. Тухайн насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн онцлог, хэрэгцээг судалж, үнэлдэг эсэх</p> <p>65. Багш нар хичээл, хөгжүүлэх ажлын төлөвлөлтийг хамтран боловсруулж, хэлэлцдэг эсэх</p> <p>66. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, чадварт нийцүүлэн томьёолж чадсан эсэх</p> <p>67. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн өдөр тутмын амьдралтай холбогдож чадсан эсэх</p> <p>68. Хөтөлбөрийн агуулга интеграцилгэсэн эсэх</p> <p>69. Хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн хөгжих, суралцах чадварын хувийн онцлог, ялгаа (хүйс, хэл, соёлын ялгаа г.м)-г тооцсон эсэх</p> <p>70. Хүүхдийн хувийн чадварыг харгалзах, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан ганцаарчлан ажилласх төлөвлөгөөтэй эсэх</p> <p>71. Хөтөлбөрийн арга зүй нь хүүхдийн ганцаараа болон жижиг бүлгээр, анги нийтээр тоглох, ажиллах боломжийг олгодог эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Багш, эцэг эхээс асуулга авах • Багшийн хөтөлбөр, хэрэгжилтдээ хийсэн өөрийн үнэлгээтэй танилцах • Багш нарын үйл ажиллагаанд ажиглалт хийх • Багшийн өдөр тутмын үйл ажиллагааны зураглалтай танилцах • Хүүхдийг ажиглах, ярилцлага хийх • Хүүхдийн хөгжлийн үнэлгээний хавтас дахь мэдээлэл, дүгнэлттэй танилцах
XVIII. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүний сонголт, хүртээмж, чанар	<p>72. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүйсийн мэдрэмжтэй эсэх</p> <p>73. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь үндэсний цөөнх, соёл, шашин шүтлэг, нийгмийн байдлаараа ялгаатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн онцлогт зохицсон эсэх</p> <p>74. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх</p> <p>75. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхдүүд ганцаараа болон хамтран хэрэглэхэд хүртээмжтэй эсэх</p> <p>76. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн сонирхол, танин мэдэх хэрэгцээг хангадаг эсэх</p> <p>77. Тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхэд сонгох боломжтой эсэх</p> <p>78. Багш тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхдэд сонирхолтой сэдэв агуулгатай уялдуулан бэлтгэж, булан төвүүдэд байрлуулан, өөрчилдэг эсэх</p>	

XIX. Сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлж, засан сайжруулдаг байдал	79. Хичээл, хөгжүүлэх ажлын явцын үнэлгээг тогтмол хийдэг эсэх 80. Багш нар бие биенхээ хичээлд сууж, шинжилгээ хийдэг эсэх 81. Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд (хүүхдийн хэрэгцээ, зорилго, зорилт, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ)-ийг боловсронгуй болгох ажлыг байнга хийдэг эсэх 82. Багш нар боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдүүд, тэдний эцэг эхэд сургалтын үйл ажиллагааны явцад дэмжлэг үзүүлдэг эсэх 83. Багш нар хүүхэд бүрийн суралцах хэв шинж, арга барилын ялгаатай байдалд мэдрэмжтэй хандаж чаддаг эсэх 84. Багш нар хүүхэд бүрийн суралцах боломж, чадавх, оролцоонд тулгуурлан сургалтын аргыг оновчтой сонгон, хэрэглэж чаддаг эсэх	
XX. Хүүхдийн хөгжил төлөвшилд гарч буй өөрчлөлт	85. Хүүхдийн бие бялдрын хөгжил, эрүүл ахуйн хэвшилд гарч буй ахиц 86. Хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд гарч буй ахиц 87. Хүүхдийн сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн хөгжилд гарч буй ахиц 88. Хүүхдийн хөгжлийн үнэлгээний хавтас бүрдүүлж, ашигладаг эсэх	
Агуулгын хүрээ: 3.2. Багш, хүүхдийн харилцаа		
XXI. Хүүхдэдтэй харилцаж буй байдал	89. Багш, ажилтнууд хүүхэд, эцэг эхтэй эелдэг харилцдаг эсэх 90. Багш нар хүүхдийн харааны түвшингөөс харилцдаг эсэх 91. Багш нар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдтэй бусад хүүхдийн адил харилцаж чаддаг эсэх	<ul style="list-style-type: none"> Багш, эцэг эхээс асуулга авах Багшийн хичээл үйл ажиллагаанд ажиглалт хийх Хүүхдийг ажиглах, ярилцлага хийх
Агуулгын хүрээ: 3.3. Эцэг эхийн сэтгэл ханамж		
XXII. Цэцэрлэгээс үзүүлж буй СӨБ-ын үйлчилгээнд эцэг эх, асран хамгаалагч сэтгэл ханамжтай эсэх	92. Хүүхдийн хөгжил, төлөвшилд гарч буй ахиц, өөрчлөлтөд эцэг эх сэтгэл ханамжтай байдаг эсэх 93. СӨБ-ын үйлчилгээний чанар, цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх сэтгэл ханамжтай эсэх 94. Эцэг эхийн санал, шүүмжийг хүлээн авч, ажилдаа тусгаж ажилладаг эсэх	<ul style="list-style-type: none"> Эцэг эхээс авсан сэтгэл ханамжийн судалгааны тайланг судлах Багшийн үйл ажиллагааны талаар эцэг эхийн бөглөсөн хяналтын хуудастай танилцах

Агуулгын хүрээ: 3.4. Цэцэрлэгийн эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний чанар

XXIII. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдал	<p>95. Багш, ажилчид жил тутам эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг эсэх</p> <p>96. Ажиллагсад нь хөдөлмөр хамгааллын (халад, хормогч, бээлий, малгай)хувцсаар бүрэн хангагдсан эсэх</p> <p>97. Цэцэрлэг дээр багш, ажилчид согтууруулах ундаа уух, тамхи татахыг хориглодог эсэх</p> <p>98. Цэцэрлэг нь эрүүл мэнд осол гэмтлийн анхны тусламж үзүүлэх тоног төхөөрөмж, хэрэгсэл, эм зэргээр хангагдсан эсэх</p> <p>99. Цэцэрлэгээс орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай холбоо харилцаа тогтоож, хамтран ажилладаг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн үзлэгийн тайлантай танилцах • Багш, эцэг эх, цэцэрлэгийн эмч, тогоочтой ярилцах • Багш, эцэг эхээс асуулга авах • Цэцэрлэгийн хоолны үйлчилгээ, тоног төхөөрөмжтэй танилцах
XXIV. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй байдал	<p>100. Бүх хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, өсөлтийн судалгаа авч, карт хөтөлж, үр дүнг тооцож ажилладаг эсэх</p> <p>101. Хөгжлийн бэрхшээлтэй, ялангуяа хараа болон сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулдаг эсэх</p> <p>102. Цэцэрлэгийн орчинд халдварт өвчин, хоолны хордлого гарахаас бүрэн сэргийлж чадсан эсэх</p> <p>103. Цэцэрлэгийн орчинд хүүхэд бэртэл, гэмтэл авахаас бүрэн сэргийлж чадсан эсэх</p> <p>104. Хүүхдэд чийрэгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг эсэх</p> <p>105. Амны хөндийн эрүүл ахуй (шүд, хоолой) болон амьсгалын замын өвчлөлийг бууруулах талаар эцэг эхтэй хамтран ажилладаг эсэх</p> <p>106. Хүүхдэд хувийн ариун цэврийг сахих (шүд, гар угаах, ам зайлах) зэрэг хэвшил тогтсон эсэх</p>	
XXV. Хоол хүнсний үйлчилгээний чанар	<p>107. Хүүхдийг амин дэм, эрдэс бодисоор баялаг, тэжээллэг хоол хүнсээр хангаж чаддаг эсэх</p> <p>108. Хоолны цэс нь хүүхдийн нас, бие, эрүүл мэндийн онцлогт тохирсон эсэх</p> <p>109. Хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд нь чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх</p> <p>110. Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан хүнсний агуулах, сав суулга хүрэлцээтэй эсэх</p> <p>111. Гал тогооны өрөө, тоног төхөөрөмжийн шинэчлэл, түүний аюулгүй ажиллагаа хангагдсан эсэх</p> <p>112. Хүүхдийн хоол тэжээл, зөв хооллолтын талаар сурталчилгааны ажлуудыг зохион байгуулдаг эсэх</p>	

Чиглэл 4: Хүүхдэд ээлтэй орчин бүрдэлт

Үнэлгээний шалгуур	Үнэлэх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Агуулгын хүрээ: 4.1. Эрх тэгш, хүртээмжтэй орчин		
XXVI. Эрх тэгш, хүртээмжтэй орчин бүрдүүлсэн байдал	113. Байгууламж, тоноглол нь бүх хүүхдэд тохиромжтой, нас болоод хөгжлийн онцлогт нийцсэн эсэх 114. Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн аюулгүй байдал, тэдний сурч хөгжих нөхцөл бололцоо хангаж чадсан эсэх 115. Бие бялдрын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд биеийн тамирын хичээл, тоглоомд оролцоо боломжийг хангасан эсэх 116. Сандал, ширээ, тоглоом, ор, бусад хэрэглэгдэхүүн материал бүх хүүхдэд хүрэлцээтэй эсэх 117. Анги танхимиын хичээл, тоглоомын булангуд нь хүүхэд ганцаараа болон бүлгээр ашиглахад хүрэлцээтэй эсэх 118. Номын сангийн баяжилт, түүний хүртээмж хангалттай эсэх	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн байгууламж, тоног хэрэгсэл, тэдгээрийн ашиглалтад ажиглалт хийх Анги танхим, хичээлийн буланг ажиглах Цэцэрлэгийн эрхлэгч, багш, туслах багштай ярилцах
Агуулгын хүрээ: 4.2. Хүйсийн мэдрэмжтэй орчин		
XXVII. Орчны хүйсийн ээлтэй байдал	119. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом, хичээл, үйл ажиллагааны агуулга нь хүйсээр ялгасан байдлаас ангид эсэх 120. Охид хөвгүүд үйл ажиллагаанд адил тэгш оролцдог эсэх 121. Охид хөвгүүд анги танхим, ариун цэврийн өрөөний тоног төхөөрөмжийг зориулалтаар нь адил тэгш ашиглах боломжтой эсэх 122. Багш, ажилтнууд бүх хүүхэд, тэдний эцэг эхийг нас, хүйсээр ялгаварлахгүй харилцдааг эсэх	<ul style="list-style-type: none"> Хичээлд ажиглалт хийх Сургалтын материал, хэрэглэгдэхүүнд анализ хийх Багшаас асуулга, ярилцлага авах Эцэг эхийн төлөөлөлтэй ярилцах
Агуулгын хүрээ: 4.3. Эрүүл, аюулгүй, хамгаалагдсан орчин		
XXVIII. Орчны ариун цэвэр, эрүүл ахуйн байдал	123. Эрүүл ахуйн шаардлага хангасан, аюулгүй ундын усаар хангагддаг эсэх 124. Тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэнгийн материал нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан ¹⁵ эсэх 125. Хүүхэд (охид, хөвгүүдийн) болон багш, ажилчдын бие засах, гар угаах газар хүрэлцээтэй, хэвийн ажилладаг эсэх 126. Эко/ногоон орчинг хангалттай бүрдүүлсэн эсэх 127. Халдварт өвчин гарахаас сэргийллэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн эсэх 128. Төсөвт цэвэрлэгээний материал, ариутгалын бодис худалдан авах зардал хангалттай тусгагдсан эсэх	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн бодлогын бичиг баримттай танилцах Цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлантай танилцах Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тэмдэглэл

¹⁵ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм”-ийн 2.2.3-р заалт

XXIX. Хүүхдийн аюулгүй, хамгаалагдсан орчин бүрдүүлсэн байдал	<p>129. Барилга, анги танхимын засвар, тоног төхөөрөмжийг тогтмол шинэчилж сэлбэдэг эсэх</p> <p>130. Цахилгаан хэрэгсэл болон санамсар болгоомжгүй үйлдлээс гэмтэж бэртэх тохиолдоос хамгаалсан орчинг бүрдүүлсэн эсэх</p> <p>131. Гадна талбайн тоглоом, биеийн тамирын талбайн тоног төхөөрөмж нь хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан эсэх</p> <p>132. Замын хөдөлгөөний аюулгүй нөхцөл хангагдсан эсэх</p> <p>133. Тусгай хэрэгцээ, хамгаалалт шаардлагатай хүүхдүүдэд ая тухтай орчин (налуу зам г.м) бүрдүүлсэн эсэх</p> <p>134. Гэнэтийн осол, гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангасан эсэх</p> <p>135. Гадаад болон дотоод орчны гэрэлтүүлгийн нөхцөл хангагдсан эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Анги танхимын засварын чанар, тоног төхөөрөмжтэй танилцах • Цэцэрлэгийн орчинтой танилцах • Багш нар, олон нийт, иргэдтэй ярилцах
---	---	---

Чиглэл 5: Гэр бүл, олон нийтийн оролцоо

Үнэлгээний шалгур	Үнэлэх үзүүлэлтүүд	Үнэлгээний баримт цуглуулах арга, хэрэглүүр
Агуулгын хүрээ: 5.1. Эрх тэгш оролцооны боломж		
XXX. Цэцэрлэгийн үйл ажиллагаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлсэн байдал	<p>136. Цэцэрлэгийн зөвлөлд эцэг эх, нутгийн иргэдийн янз бүрийн бүлгийн төлөөлөл (хүйс, үндэсний цөөнх, ядуу амьдралтай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд г.м) –ийг адил тэгш оролцуулсан эсэх</p> <p>137. Цэцэрлэгээс эрхлэн гаргаж буй мэдээллийн хуудас, сонин, цахим хуудас ээргийг тухайн орон нутгийн үндэсний цөөнхийн хэл дээр уншиж танилцах боломжийг хангасан эсэх</p> <p>138. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээтэй холбоотой асуудлаар орон нутгийн иргэд, байгууллага санал бодлоо илэрхийлэх механизмыг бүрдүүлсэн эсэх</p> <p>139. Эцэг эх хүссэн үедээ хүүхдийнхээ сурч хөгжих буй орчинтой танилцах, хэрэглэж буй хүнс тэжээлийн зүйлд хяналт тавих, мэдээлэл авах боломжтой эсэх</p> <p>140. Цэцэрлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд шууд оролцох боломжгүй байгаа эцэг эхэд өөр арга замаар оролцох боломж олгодог эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Баримт бичигтэй танилцах • Эцэг эх, олон нийт, цэцэрлэгийн хамтарсан зөвлөлийн уулзалт, хурлын тэмдэглэлд дүн шинжилгээ хийх • Эцэг эхийн төлөөлөл, цэцэрлэгийн зөвлөлийн гишүүдтэй фокус бүлгийн ярилцлага хийх

Агуулгын хүрээ: 5.2. Гэр бүлийн оролцоо, хамтын ажиллагаа

<p>XXXI. Эцэг эх, гэр бүлтэй харилцаа тогтоосон байдал</p> <p>XXXII. Гэр бүл, эцэг эхтэй хамтран ажиллаж буй байдал</p>	<p>141. Эцэг эхчүүд, цэцэрлэгийн зөвлөлийн гишүүд, эцэг эхийн зөвлөлд цэцэрлэгийн үйл ажиллагаа, эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний талаарх мэдээллийг тогтмол хүргэдэг эсэх</p> <p>142. Эцэг эхэд хүүхдийн хөгжилд гарч буй ахиц, өөрчлөлтийн талаар мэдээллийг тогтмол өгдөг эсэх</p> <p>143. Эцэг эхчүүд хүүхдийнхээ эрүүл мэнд, хөгжлийн талаар санаа зовьж байгаа асуудлаар цэцэрлэг дээр очиж зөвлөгөө авч болно гэдгээ мэддэг эсэх</p> <p>144. Эцэг эхэд ямар туслалцаа, дэмжлэг хэрэгтэйг судалж, тодруулдаг эсэх</p> <p>145. Эцэг эхийн сонирхол, авьяас чадварыг судалж, тэдний чадавхийг цэцэрлэгийн үйл ажиллагаатай уялдуулдаг эсэх</p> <p>146. Эцэг эхчүүдэд зориулсан сургалт (тэгш хамран сургах бодлого, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, төсөв, түүний зарцуулалт, хүүхдийн эрүүл, аюулгүй, хамгаалагдсан байдал, хүйсийн мэдрэмж, гэр бүл дэх хүүхдийн хүмүүжлийн чиглэлээр) зохион байгуулдаг эсэх</p> <p>147. Хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад эцэг эхийг оролцуулдаг эсэх</p> <p>148. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг эцэг эхтэй хамтран үнэлдэг эсэх</p> <p>149. Бүх хүүхэд, тэдний угсаа гарал, соёл, хэл яриа, хөгжлийн түвшин, хүйс, нийгэм эдийн засгийн байдал зэргээсээ үл хамааран цэцэрлэгт хамрагдах; боломжгүй тохиолдолд сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтад хамрагдах шаардлагатай гэдгийг хүүхдээ цэцэрлэгт хамруулаагүй эцэг эхэдuriалсан ухуулга, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулдаг эсэх</p> <p>150. Эмзэл булгийн болон цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн гэр бүл, эцэг эхтэй хамтран ажилладаг эсэх</p> <p>151. Хамран сургах тойргийн бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зөвлөгөө өгч, тэдэнд мэргэжлийн туслалцаа үзүүлдэг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн зөвлөлийн ба цэцэрлэгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд анализ хийх • Цэцэрлэгийн зөвлөлийн хурлын тэмдэглэл • Эцэг эхээс асуулга, сэтгэл ханамжийн судалгаа авах • Цэцэрлэгт зохион байгуулсан сургалт семинариудын төлөвлөгөө, тайлантай танилцах • Эцэг эхийн төлөөлөлтэй уулзаж ярилцах
---	---	---

XXXIII. Шийдвэр гаргах үйл явцад эцэг эхийг оролцуулах механизм бүрдүүлсэн байдал	<p>152. Эцэг эхчүүдэд цэцэрлэгийн үйл ажиллаганд оролцох боломжтэгш олгодог (мэдээлэл жигд хүрдэг, туршлага, санал бодлоо солилцох боломж адил олддог) эсэх</p> <p>153. Багш – эцэг эх – олон нийтийн хамтарсан зөвлөл (цэцэрлэгийн зөвлөл)-тэй эсэх</p> <p>154. Цэцэрлэгийн зөвлөл нь ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтарч ажилладаг эсэх</p> <p>155. Эцэг эхчүүдийг шийдвэр гаргах, бодлого боловсруулахад оролцуулдаг эсэх</p> <p>156. Шийдвэр гаргах үйл явцад оролцогч талууд хүндэтгэлтэй, бүрэн эрхтэй оролцох нөхцлийг бүрдүүлсэн эсэх</p> <p>157. Эцэг эх, гэр бүлийн оролцоог үнэлж, урамшуулдаг эсэх</p>	
Агуулгын хүрээ: 5.3. Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа		
XXXIV. Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд олон нийтийн хүч, нөөцийг ашиглах механизмыг бүрдүүлсэн байдал	<p>158. Цэцэрлэгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол түгээдэг эсэх</p> <p>159. Орон нутгийн нөөцдөө тулгуурлан сайн дурынхны дэмжлэг, оролцоог буй болгосон эсэх</p> <p>160. Тухайн орон нутгийн үндэсний цөөнхтэй хамтран тэдний соёл, уламжлалыг сурталчилсан ажил зохион байгуулдаг эсэх</p> <p>161. Сургалтын материалыг орон нутгийн онцлог нөхцөл байдал, тэгш хамран сургах хэрэгцээ шаардлагад тохишуулан шинэчлэх, дахин боловсруулахад нутгийн иргэд (ялангуяа үндэсний цөөнхийн төлөөлөл, хөгжлийн бэрхшээлтэй иргэд)–ийг татан оролцуулдаг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн үйл ажиллагааны болон үнэлгээний тайлантай танилцах • Цэцэрлэгийн удирдлага ба орон нутгийн удирдлагатай ярилцах • Цэцэрлэгээс гаргасан ханын самбар, фото зургийн цомог, орон нутгийн олон нийтийн байгууллагын сонин, мэдээллийн ба цахим хуудастай танилцах
XXXV. Цэцэрлэг нь орон нутгаасаа дэмжлэг авч, хамтран ажилладаг байдал	<p>162. Орон нутаг нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа бүх хүүхдийг цэцэрлэгт хамруулах, тэдэнд хүрч үйлчлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлдэг эсэх</p> <p>163. Хүүхдийн амьдрал, хөгжил, суурьшил (алслагдсан баг, отгийн өрх, шилжин ирэгсэд г.м) зэрэгээс үл хамааран бүх хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиүүлэхэд төрийн ба төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтарч ажилладаг эсэх</p> <p>164. Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад орон нутгийн засаг захиргааны болон хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудтай хамтран ажилладаг эсэх</p> <p>165. Өөрийн үнэлгээ хийх, цэцэрлэг хөгжүүлэх төлөвлөгөө, төсвийг боловсруулж, хэлэлцүүлэхдээ орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулж, дүгнэлт санал авдаг эсэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цэцэрлэгийн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт оролцогсдын бүрд гэл, уулзалтын тэмдэглэл

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

Хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн өөрийн үнэлгээний хэрэгсэл

2.1. Эцэг эхээс авах үнэлгээний хуудас

Та өөрийнхөө хүүхдийн бодит байдлыг өгөгдсөн бодомжуудын санаатай хэр ойр байгаагаар баримжаалж хариултыг сонгоорой. Хариулах боломжгүй, юу гэж хариулахаа сайн мэдэхгүй бол “Х” буюу мэдэхгүй гэсэн баганы харгалзах мөрөнд тэмдэглэгээ хийнэ үү. Сэтгэл дундуур байгаа хариултдаа тайлбар бичвэл сайн. Таны хариулт бодитой байхын хэрээр цэцэрлэг, багш нарын үйл ажиллагааг цаашид сайжруулах чиг санаа зөв гарах тул аль болох бодитой, үнэн зөв хариулахыг хичээгээрэй.

Хүснэгт 3. Эцэг эхийн үнэлгээний хуудас

Миний хүүхдийн хөгжил	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхийн жадал	Тайлбар
1. Миний хүү/охины өндер, жин зэрэг нь үе тэнгийн бусад хүүхэдтэй ойролцоо.					
2. Миний хүү/охин гүйх, харайх, үсрэх үйл хөдөлгөөнийг бие даан хийж чадна.					
3. Миний хүү/охин хувцсаа бие даан өмсөж, тайлж чаддаг.					
4. Миний хүү/охин гарaa бие даан угааж чаддаг.					
5. Миний хүү/охин шүдээ бусдын туслалцаагүйгээр угааж чаддаг.					
6. Миний хүү/охин овог нэрээ бүрэн, зөв хэлж чадна.					
7. Миний хүү/охин гэртээ байгаа эд юмын адил ба ялгаатай талыг хэлж чаддаг.					
8. Миний хүү/охин байгалийн үзэгдэл юмын талаар сонирхон асууж, ярилцдаг.					
9. Миний хүү/охин гэртээ байгаа хамгийн олон эсвэл цөөн зүйлийг тоолоод хэлж чадна.					
10. Миний хүү/охин 10 хүртэл тоолж чаддаг.					
11. Миний хүү/охин үндсэн өнгө (улаан, цэнхэр, ногоон, шар гэх мэт)-ийг ялгаж таньдаг.					

12. Миний хүү/охин өөрөөрөө (гэрээрээ) баримжаалан юмсын зүг чиг, байрлалыг хэлж чадна.					
13. Миний хүү/охин бусдад ойлгомжтой ярьдаг.					
14. Миний хүү/охин үлгэр сонсох, өөрөө ярих дуртай.					
15. Миний хүү/охин шүлэг уншиж чадна.					
16. Миний хүү/охин гэрийн хаягаа мэднэ, хэлж чадна.					
17. Миний хүү/охин гэр бүлийнхээ гэрэл зургийн цомгийг танилцуулж чадна.					
18. Миний хүү/охин өөрийн хүсэл, санаа бодлоо үгээр илэрхийлж чадна.					
19. Миний хүү/охин бусдад (эцэг эх, багш, найз г.м) асуулт тавьж, бусдын асуултад хариулж чадна.					
20. Миний хүү/охин ууртай, сэтгэл таагүй байгаагаа үгээр илэрхийлдэг.					
21. Миний хүү/охин бусад хүний таагүй байгааг мэдэрдэг.					
22. Миний хүү/охин “Баярлалаа”, “Уучлаарай”, “Зүгээр”, “... болох уу?” гэх зэрэг үгийг хэрэглэдэг.					
23. Миний хүү/охин бусад хүүхдүүдтэй нөхөрсөг тоглож чадна.					
24. Миний хүү/охин бусадтай тоглоом, эд зүйлээ хуваалцдаг.					
25. Миний хүү/охин гэр бүлдээ баримтالдаг ёс, заншлыг дагаж мөрддөг.					
26. Миний хүү/охин ахмад хүнтэй мэндэлж, тэднийг хүндэтгэдэг.					
27. Миний хүү/охин бидний өгсөн сургаал, зөвлөгөөг сонсож биелүүлдэг.					

Миний хүүхдийн аюулгүй байдал ба хамгаалал	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайкруулах шаардлагатай.	Үгүй	Мэзэхгүй	Тайлбар
28. Миний хүү/охин цэцэрлэгийн орчинд бэртэж, гэмтэж байгаагүй.					
29. Миний хүү/охин цэцэрлэгтээ эрүүл, чанартай хоол, хүнс хэрэглэдэг.					
30. Миний хүүхдийн цэцэрлэг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангагддаг.					
31. Миний хүү/охины тоглоом наадгай нь цэвэрхэн, аюулгүй.					
32. Миний хүү/охин цэцэрлэг дээрээ зориулалтын, цэвэрхэн бие засах, гар угаах газрыг ашигладаг.					
33. Миний хүү/охины цэцэрлэг тасалгааны цэцэг ургамал тарьж ногоон орчин бүрдүүлсэн.					
34. Миний хүү/охины цэцэрлэг халдварт өвчнөөс сэргийлэх нөхцлийг бүрдүүлсэн .					
35. Миний хүү/охины цэцэрлэгт осол, аюулгүй байдлын дүрмийг мөрддөг.					
36. Миний хүү/охины анги танхим, цэцэрлэгт засвар хийж, шинэчилсэн.					
37. Миний хүү/охин цэцэрлэгийн гадна болон биеийн тамирын талбайдаа аюулгүй, найдвартай тоглоом, хэрэглэгдэхүүнийг ашигладаг.					
38. Манай хүүхдийн цэцэрлэг авто замаас 50м, орчныхoo гудамж замаас 25м хол зйтай байрладаг.					
39. Манай хүүхдийн цэцэрлэг 1.6 м хүртэл өндөртэй хашаатай.					

40. Миний хүү/охины цэцэрлэгт явдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд ая тухтай орчин (налуу шат г.м) бурдүүлсэн.					
41. Миний хүү/охин цэцэрлэг дээр нь цохих, чимхэх, загнах (уг хэлээр доромжлох) зэргээр шийтгүүлж байгаагүй.					
42. Миний хүү/охиньг цэцэрлэг гэнэтийн осол гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангасан.					
43. Цэцэрлэг гадаад, дотоод орчны гэрэлтүүлэг сайтай.					

Миний хүүхдийн эрүүл мэнд	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхгүй	Тайлбар
44. Миний хүүхэд цэцэрлэг дээрээ эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг.					
45. Миний хүү/охиниг нарийн мэргэжлийн эмч(шүд, нүд, чих хамар хоолой, мэдрэл г.м)-д үзүүлэхийг цэцэрлэгээс зөвлөдөг.					
46. Цэцэрлэгийн багш, эмчийн зүгээс надад хүүхдийнхээ амны хөндийн эрүүл ахуйд хяналт тавих, амьсгалын замын өвчинөөс сэргийлэх талаар зөвлөгөө өгдөг.					
47. Миний хүү/охинд цэцэрлэг дээр эмнэлэгийн тусламж, эмчилгээ үзүүлсэн тохиолдолд надад мэдэгдэх байсан.					
48. Миний хүү/охин цэцэрлэгтээ вакцинуулалтад хамрагдсан.					
49. Миний хүү/охин цэцэрлэгээс халдварт өвчин, хоолны хордлого авч байсан тохиолдол байхгүй.					
50. Манай хүүхэд цэцэрлэг дээрээ чийрэгжүүлэх хөтөлбөрт хамрагддаг.					
51. Манай хүүхэд цэцэрлэгээсээ нэмэлт хоол тэжээл хэрэглэж байсан.					
52. Манай хүүхэд цэцэрлэг дээрээ тэжээллэг чанартай эрүүл, аюулгүй хоол хүнс хэрэглэдэг.					

Миний хүүхдийн суралцаж, хөгжиж байгаа орчин	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхийн тайлбар
53. Манай хүүхдийн багш өглөө бүр мэндэлж, надтай эелдэг харилцдаг.				
54. Би хүүхдийнхээ хөгжил, төлөвшлийн асуудлаар багштай нь чөлөөтэй ярилцдаг.				
55. Миний хүү/охиньг багш нь анхааралтай сонсдог.				
56. Багш нь миний хүү/охинь биед хүрч, уг хэлээр доромжилж байсан тохиолдол гарцаагүй.				
57. Цэцэрлэгийн багш, ажилтнууд хүүхдийн дэргэд бүдүүлэг уг хэлэх, зүй бус үйлдэл хийсэн тохиолдол гарч байгаагүй.				
58. Миний хүү/охинь цэцэрлэг нь чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжтэй.				
59. Цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмж миний хүүхдийн нас, хөгжлийн онцлогт тохирсон.				
60. Миний хүү/охин цэцэрлэг дээрээ хувцас солих шүүгээтэй.				
61. Миний хүү/охин цэцэрлэгтээ цагаан хэрэглэл, гудсыг тусдаа хэрэглэдэг.				
62. Миний хүү/охинь ангийн сандал, ширээ нь хүрэлцээтэй.				
63. Миний хүү/охинь ангийн тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн нь хангалттай.				
64. Миний охин/хүү тоглоом, үйл ажиллагаанд хөвгүүд/ охидын адил оролцдог.				

Миний хүүхдийн суралцаж, хөгжиж байгаа орчин	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхийн	Тайлбар
65. Миний хүү/охин анги танхим, ариун цэврийн өрөөний тоног төхөөрөмжийг бусад охид/хөвгүүдийн адил хүрэлцээтэй ашигладаг.					
66. Миний хүү/охины багш намайг аливаа зүйлээр ялгаварлах, алагчлах байдал гаргаж байгаагүй.					

Миний оролцоо	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэзхүүк	Тайлбар
					X
67. Би цэцэрлэгийн үйл ажиллагааг сурталчлах өдрийн үйл ажиллагаанд оролцож байсан.					
68. Би цэцэрлэгээс зохион байгуулсан хүүхдийн хөгжил, хоол тэжээл, зөв хооллолтын тухай яриа танилцуулгад хамрагдсан.					
69. Манай хүүхдийн цэцэрлэгээс манай нутгийн үндэсний цөөнхийн (казак, тыва г.м) хэл дээр мэдээлэл гаргадаг.					
70. Манай хүүхдийн цэцэрлэг миний хүүхдийн төлөө ямар бодлого баримталж, ямар дүрэм журам мөрдөж байгааг би мэднэ.					
71. Надад цэцэрлэг дээр бидний хүүхэдтэй холбоотой чухал асуудал хэлэлцэх, шийдвэр гаргахад оролцоо боломж бусад эцэг эхчүүдтэй адилхан олддог.					
72. Манай хүүхдийн цэцэрлэгт цэцэрлэгийн зөвлөл байдаг.					
73. Цэцэрлэгийн зөвлөл нь манай хүүхдийн ангийн эцэг эхийн зөвлөлтэй хамтарч ажилладаг.					
74. Би цэцэрлэг дээр эцэг эхийн хурал, уулзалт, цуглаанд оролцдог.					
75. Би цэцэрлэгээс эцэг эхчүүдэд зориулан зохион байгуулсан сургалтад оролцсон.					
76. Би цэцэрлэгийн үйл ажиллагаа, эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний талаархи мэдээллийг тогтмол хүлээн авдаг.					

Миний оролцоо	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мээхгүй	Тайлбар
					X
77. Би хүссэн үедээ хүүхдийнхээ идэж, ууж буй хүнс, ундаа, өсч торниж буй орчинтой нь танилцах боломжтой.					
78. Би хүүхдийнхээ эрүүл мэнд, хөгжилтэй холбоотой асуудлаар цэцэрлэгийн багш, ажилтнуудаас зөвлөгөө авах, ярилцах боломжтой.					
79. Миний хүү/охины хөгжилд ямар ахиц өөрчлөлт гарч байгаа талаар цэцэрлэг надад мэдээлэл өгдөг.					
80. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд, тэдний ээж аавд цэцэрлэгийн зүгээс тусалж, тэдэнтэй ажилладаг.					
81. Би цэцэрлэгээс зохион байгуулсан гэр бүл, эцэг эхэд зориулсан өдөрлөгт уригдаж, оролцож байсан.					
82. Миний хүү/охины хөгжил төлөвшлийг үнэлэхэд намайг оролцуулж байсан.					
83. Миний болон манай гэр булийнхний оролцоонд талархаж, урам хайрлаж байсан.					
84. Би цэцэрлэг болон манай гэр булийн хамтын ажиллагаанд сэтгэл ханамжтай байдаг.					

Миний сэтгэгдэл	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхүй	Тайлбар
85. Би хүүхдийнхээ цэцэрлэгийн эрхэм зорилтыг ойлгож дэмжиж хамтран ажилладаг.					
86. Цэцэрлэг миний санал хүсэлтэд мэдрэмжтэй ханддаг.					
87. Надад цэцэрлэгийн эрүүл мэнд, хоол хүнсний цогц үйлчилгээ үзүүлэх бодлого нь таалагддаг.					
88. Миний ажигласнаар, цэцэрлэг дээр аливаа ялгаварлан гадуурхах, алагчлах(хүис, хэл, соёл, нийгмийн байдал, баян, ядуу, насаар) үзэгдэл гарч байгаагүй.					
89. Би цэцэрлэгийн үйл ажиллагааны нээлттэй байдалд (үйл ажиллагаандаа үнэлгээ хийж, эцэг эхэд тайлагнадаг) сэтгэл ханамжтай байдаг.					
90. Багш нь миний хүү/ охины онцлог ялгаа, хувийн хэрэгцээг үйл ажиллагаандаа харгалзаж чаддаг.					
91. Манай хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтнууд надтай зөлдэг, хүндэтгэлтэй харилцдаг.					
92. Багш нь миний хүү/охиньг амжилттай сурч, хөгжиж чадна гэдэгт итгэдэгт би талархдаг.					
93. Цэцэрлэг миний хүүхдэд бусад хүүхдийн адил суралцах, бүх талаар хөгжих боломжийг адил тэгш олгож байгаад би сэтгэл хангалуун байдаг.					

Миний сэтгэгдэл	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайкруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхүй	Тайлбар
					X
94. Цэцэрлэгт явснаар миний хүүхдийн хөгжил төлөвшилтэд гарч буй ахиц өөрчлөлтөд би сэтгэл ханамжтай байна.					
95. Би хүүхдийнхээ цэцэрлэгийн үйл ажиллагаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг.					
96. Цэцэрлэг үйл ажиллагаандaa эцэг, эхчүүдийн санал, шүүмжийг тусгадаг гэж үзэж байна.					
97. Би иргэн хүний хувьд манай орон нутгаас цэцэрлэгт үзүүлж буй дэмжлэг туслалцаанд сэтгэл хангалуун байдаг.					

Миний санал:

1/ Цэцэрлэгт хүүхдэд ээлтэй, ая тухтай орчин бүрдүүлэхийн тулд дараах зүйлийг хиймээр байна:

- 1 _____
- 2 _____
- 3 _____

2/ Таны бодлоор цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхийг жигд, идэвхтэй оролцуулахын тулд юу хийж хийж болох вэ?

3/ Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдүүдэд хүрч үйлчлэх нэг арга замыг санал болговол:

4/ Таны бодлоор цэцэрлэгийг хүүхдэд ээлтэй болгохын тулд юуг өөрчлөх шаардлагатай вэ?

1 _____

2 _____

3 _____

5/ Цэцэрлэгт мөрдвөл зохих зүйл бол _____

6/ Таны бодлоор цэцэрлэгийн ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд юуг тусгах шаардлагатай вэ?

2.2. Эцгэг эхийн бүлэгтэй хийх ярилцлагын чиглэл

1. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар
 - Цэцэрлэгийн үйлчилгээ, үйл ажиллагаа сэтгэлд хүрч буй эсэх?
 - Хүүхдийнхээ хөгжил, төлөвшилд гарч буй өөрчлөлтөд хэр сэтгэл ханамжтай байдаг вэ? Юун дээр нь илүү анхаараасай гэж боддог вэ?
 - Цэцэрлэгийн багш, ажилтнууд хүүхэдтэй хэр харилцдаг вэ?
 - Цэцэрлэгийн эрүүл мэнд, хоол хүнсний үйлчилгээний чанар хэр зэрэг вэ? Цаашид юуг анхаарах шаардлагатай вэ?
2. Цэцэрлэг, гэр бүлийн хамтын ажиллагаа
 - Эцгэг эх цэцэрлэгийн зүгээс ямар дэмжлэг туслалцаа хүсдэг вэ?
 - Эцгэг эхчүүдэд зориулсан сургалт, семинарийг ямар чиглэл, сэдвийн хүрээнд зохион байгуулах хэрэгтэй вэ?
 - Та бүхэнд цэцэрлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход юу нэлөөлдөг вэ? Харин юу саад болдог вэ?
 - Бүх эцгэг эхийг (ялангуяа аав нарыг) цэцэрлэгийн үйл ажиллагаанд жигд идэвхтэй оролцуулахын тулд юу хийж болох вэ?
 - Ангийн болон цэцэрлэгийн эцгэг эхийн зөвлөлөөс цэцэрлэгийг хүүхэд бүрд ээлтэй орчин болгоход ямар дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллаж болох вэ?
3. Үнэлгээ, оролцоонд тулгуурласан төлөвлөлт
 - Цэцэрлэгийн өөрийн үнэлгээнд оролцсон хүмүүсийн хувьд, цэцэрлэг ойрын хугацаанд юуг өөрчлөх шаардлагатайг хэлнэ үү?

- Цэцэрлэг цаашид юун дээр төвлөрч ажиллах хэрэгтэй вэ?
- Цэцэрлэгийн ирэх жилийн төлөвлөгөөнд заавал тусгах шаардлагатай зүйл юу вэ?

2.3. Эцэг эхтэй хийх ганцаарчилсан ярилцлагын асуулт

(Хүүхэд нь цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа эцэг эхийн төлөөлөл оролцно)

1. Танай сум/хорооны цэцэрлэг бага насын хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулан ямар нэг ажил зохион байгуулдаг уу? Хэрэв тийм бол та оролцож байсан уу?
2. Хүүхдээ сургуулийн өмнөх боловсролд хамруулах боломж, арга замын талаар цэцэрлэгээс танд мэдээлэл өгч байсан уу? Хэрэв тийм бол та ямар мэдээлэл авч, хэрхэн ашиглаж байсан бэ?
3. Танай хүү/охин цэцэрлэгт явж чадахгүй байгаа гол шалтгаан нь юу вэ?
4. Танай хүүхэд цэцэрлэгийн хувилбарт сургалтад хамрагдсан уу? Хэрэв тийм бол хэдий хэр хугацаанд явсан бэ? Хэрэв үгүй бол, яагаад хамрагдаж чадаагүй вэ?
5. Таны бодлоор, цэцэрлэгээс зохион байгуулж буй хувилбарт сургалт хэр үр дүнтэй байна вэ?
- Хугацаа
- Хүүхэд шинээр сурч эзэмшсэн зүйл
- Эцэг эх, гэр бүлд үзүүлж буй нөлөө
- Бэрхшээл, хүндрэл
6. Хүүхэд нь цэцэрлэгт хамрагдаагүй эцэг эхчүүдэд цэцэрлэг ямар дэмжлэг, туслалцаа үзүүлэх шаардлагатай вэ?
7. Танай орон нутгийн нэхцөлд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд ямар арга замаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх боломжтой гэж та боддог вэ?

2.4. Багшаас авах үнэлгээний хуудас

Та ангийнхаа хүүхдүүдийн олонхиийн хувьд уг асуудал ямар байгаа гэж үзэж байгаагаар баримжаалж хариултыг сонгоорой. Хариулах боломжгүй, юу гэж хариулахаа сайн мэдэхгүй бол “**X**” буюу мэдэхгүй гэсэн баганы харгалзах мөрөнд тэмдэглэгээ хийнэ үү. Сэтгэл дундуур байгаа хариултдаа тайлбар бичвэл сайн. Таны хариулт бодитой байхын хэрээр үйл ажиллагаагаа цаашид сайжруулах санаа, арга замыг хамтдаа олох тул аль болох бодитой, үнэн зөв хариулахыг хичээгээрэй.

Хүснэгт 4. Багшаас авах үнэлгээний хуудас

Манай ангийн хүүхдүүдийн хөгжил/ахиц дэвшил	Тийм	Ер нь тийм, гэхдээ сайжруулах шаардлагатай.	Үгүй	Мэдэхгүй	Тайлбар
1. Бие даан биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг хийж чадна.					
2. Хөдөлгөөнт тоглоом, дасгал даалгаврыг гүйцэтгэх явцад тодорхой дүрэм журмыг баримтлахыг мэддэг.					
3. Шаардлагатай утасны дугаарыг мэддэг.					
4. Авиа, үе, үг, өгүүлбэрийг сонсож, зөв дуудаж, үгийн нөөц нэмэгдсэн.					
5. Өөрийн санаа бодлыг зөв яруу тод, илэрхийлэн ярьж чадна.					
6. Бусадтай мэдээлэл солилцож, тэмдэг тэмдэглэлээг уншиж чадна.					
7. Тоо тооны үйлдэл, хэлбэр дүрс, орон зай, цаг хугацааны тухай мэдлэгийг өдөр тутам хэрэглэж чаддаг.					
8. Өөрт тулгарсан асуудлыг бодох, хэмжих, турших, зохиох, барьж бүтээх, харилцан ярилцах зэргээр шийдвэрлэх арга замыг олж чадна.					
9. Зурах, барих, наах, зохион бүтээх, өөрийн санааг бүтээлээрээ илэрхийлж чадна.					

10. Өөрийн болон бусдын бүтээлийг ажиглан бүтээлээ тайлбарлан ярьж, хамтарч бүтээл хийдэг.				
11. Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийж чадна.				
12. Гэр бул, найз нөхөд, ахмад хүмүүсийг хүндэтгэж, эелдэг зөв харилцаг.				
13. Гар, нүүрээ бие дааж угаадаг.				
